

Байгаль орчинд нөлөөлөх  
байдлын үнэлгээнд олон нийтийн  
оролцоог хангах талаарх олон  
улсын туршлага

Энэхүү тайланг Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас тавьсан хүсэлтийн дагуу Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөрийн (АМЕП2) хүрээнд боловсруулсан бөгөөд АМЕП 2 хөтөлбөрийг Австрали Улсын Гадаад харилцаа худалдааны яам санхүүжүүлэн, Адам смит Интернэйшнл компани хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах талаарх олон улсын туршлага**

Энэ тайланг “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 2014 онд батлагдсан БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах тухай журмыг боловсронгуй болгох төслийн хүрээнд боловсруулав.

Тайлан боловсруулсан: АМЕП-2 төслийн олон нийтийн оролцооны зөвлөх Доктор Д.Бямбажав

2021 оны 6 сарын 15

## Гарчиг

Товчилсон үгийн жагсаалт .....	4
Оршил .....	5
Хөрш зэргэлдээ улсуудын туршлага .....	6
Бүгд Найрамдах Хятад Ард Улс .....	6
Оросын Холбооны Улс .....	15
Бүгд Найрамдах Солонгос Улс .....	20
Казакстан .....	24
Хөгжиж буй ижил төстэй улсуудын туршлага .....	27
Ботсвана .....	27
Перу .....	29
Уул уурхай түшиглэсэн эдийн засгийн өндөр хөгжилтэй улсын туршлага .....	36
Австрали, Күинсланд муж .....	36
Монгол улс ба олон улсын туршлагын харьцуулалт .....	41
Дүгнэлт, зөвлөмж .....	44
Хавсралт .....	48

## **Товчилсон үгийн жагсаалт**

БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард улс
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОГ	Байгаль орчны газар
БОЯ	Байгаль орчны яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОННУ	Байгаль орчин нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ
ЕҮД	Ерөнхий үнэлгээний дүгнэлт
ОХУ	Оросын Холбооны Улс
СНҮ	Стратегийн нөлөөллийн үнэлгээ
ТБҮ	Төлөв байдлын үнэлгээ
ТУХН	Тусгаар улсуудын хамтын нөхөрлөл

## Оршил

БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах талаарх олон улсын судалгаа, бодлогын болон эрх зүйн эх сурвалжууд, Монгол улсын нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, БОНБҮ-ний тогтолцооны онцлогийг харгалзан үзээд дараах улс орнуудын туршлагыг дэлгэрүүлэн судлах нь үр дүнтэй гэж үзсэн. Үүнд:

1. Монгол улсын гео-эдийн засгийн онцлог, бүс нутгийн хамтын ажиллагааны чиг хандлагыг харгалзан үзэж БНХАУ, ОХУ, БНСУ, Казакстан улсын туршлагыг судлан үзэх шаардлагатай. Эдгээр улсыг сонгохын өмнө Төв Ази, Зүүн Өмнөд Азийн улс орнуудын БОНБҮ-ний тогтолцоо, түүнд олон нийтийн оролцоог хэрхэн хангаж буй талаар тойм судалгаа хийсэн.
2. Хөгжиж буй улс орнуудын хувьд БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт сорилт хэвээр байна. Олон улсын харьцуулсан судалгаанд үндэслэн БОНБҮ-ний тогтолцооны хөгжил болон олон нийтийн оролцоог хангах ахиц дэвшлийн хувьд онцлог гэж дүгнэн Ботсвана болон Перу улсыг сонгон судалсан. Ботсвана улс нь уул уурхайн эдийн засагт оруулах хувь нэмэр өндөр, далайд гарцгүй, хүн ам багатай, Африкийн хөгжиж буй улс юм. Перу улсын хувьд уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа БОНБҮ-тэй холбоотой орон нутгийн иргэдийн эсэргүүцэл, зөрчилдөөн маш их гардаг улс бөгөөд сүүлийн жилүүдэд БОНБҮ-ний тогтолцоогоо боловсронгуй болгох, нийгмийн итгэлийг нэмэгдүүлэх шинэчлэл хийсэн.
3. Эдийн засгийн өндөр хөгжилтэй ихэнх улс орнууд, ялангуяа Европ, Хойд Америкийн улс орнууд, Австрали, Шинэ Зеланд, Япон зэрэг улсад олон нийтийн оролцоог хангах нь БОНБҮ-ний тогтолцооны салшгүй нэг хэсэг болон тогтсон байна. Эдгээрээс уул уурхай, ХАА, аялал жуулчлалын салбарын хөгжлийн хувьд жишиг болохуйц Австралийн Квинсланд мужийн туршлагыг судлан үзэх нь ач холбогдолтой гэж үзсэн. Эдгээр улсуудын хувьд БОНБҮ-ний тогтолцоо нь эдийн засгийн нөөц боломж, эрх зүйн нарийвчилсан зохицуулалт, улс төр, иргэний оролцооны соёл зэрэг олон хүчин зүйлээр дэмжигдэж байдгийг анхаарах хэрэгтэй юм.

Сонгон авсан улс орнуудын туршлагыг дараах ерөнхий асуудлуудын хүрээнд судлан үзсэн. Үүнд:

1. БОНБҮ-ний тогтолцооны онцлог
2. БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах зохицуулалт
3. Монгол улсын хувьд чухал ач холбогдолтой туршлага сургамжууд

## Хөрш зэргэлдээ улсуудын туршлага


### Бүгд Найрамдах Хятад Ард Улс

#### БОНБУ-ний тогтолцоо

БОНБУ-ний бие даасан хуулийг 2002 онд баталсан байна. Энэ хуульд нийцүүлэн төслийн БОНБУ хийх журам, төрийн бодлого, төлөвлөгөөний БОНБУ буюу стратегийн нөлөөллийн үнэлгээний журам батлагдсан байна.

Хятадын засгийн газраас БОНБУ-ний тогтолцоог боловсронгуй болгох, ялангуяа тайланг хянан үзэх, батлах үйл явцын төвлөрлийг сааруулах, аж ахуйн нэгж, иргэдэд ойр дөт болгох бодлогыг 2013 оноос хэрэгжүүлсэн. Улмаар БОНБУ-ний тайланг батлах эрхийг Байгаль орчны яам /БОЯ/-наас аймаг, орон нутгийн байгаль орчны газруудад /БОГ/ үе шаттай шилжүүлсэн. Өнөөгийн байдлаар БНХАУ-ын БОЯ нь цөмийн эрчим хүч зэрэг онцгой ач холбогдолтой төслүүд, хэд хэдэн муж дамнасан төслүүд, Төрийн Зөвлөлөөс баталсан стратегийн төслүүдийг л хянан үзэж, баталж байна.<sup>1</sup>

Бүдүүвч 1. БНХАУ-ын БОНБУ-ний ангилал



Түүнчлэн, бүхий л төрлийн БОНБУ-ний тайланг байгаль орчны холбогдох байгууллагууд дангаар баталдаг байсныг 2016 оноос өөрчилж холбогдох салбарын эрх бүхий байгууллагын саналыг авч, харилцан уялдааг хангах бодлого хэрэгжүүлсэн байна.

<sup>1</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс уншиж болно: J. Wu and I.-S. Chang, Environmental Management in China, [https://doi.org/10.1007/978-981-15-4894-9\\_4](https://doi.org/10.1007/978-981-15-4894-9_4)

Аж үйлдвэр, тээвэр, усан хангамж, хөдөө аж ахуй, ойн аж ахуй, үйлчилгээ, боловсрол, аялал жуулчлал зэрэг олон чиглэлийн төслүүдийг үнэлгээ хийх төслийн ангилалд багтаасан байна. БОЯ-наас БОНБУ-ний ангиллын каталогийг гаргадаг бөгөөд үүнд тухайн чиглэлийн төслийн хувьд үнэлгээ хийлгэх шаардлагатай, тийм бол ямар төрлийн үнэлгээ хийлгэх хэрэгтэйг төслийн байршил, чиглэл, төслийн хэмжээ, хөрөнгө оруулалт, бохирдуулагч бодисын төрөл, хэмжээ, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн их, багаас хамаарч тодорхойлсон байдаг /Хүснэгт 1/. Төслийн газарзүйн байршил буюу байгаль орчны эмзэг байдал аль ангилалд хамааруулахад чухал хүчин зүйл болдог байна.

БОНБУ-ний хуульд зааснаар төслийн БОНБУ-г төслийн байгаль орчин үзүүлэх байдлын зэргээс хамаарч дараах 3 төрөлд ангилдаг. Үүнд:

1. Хэрэв нөлөөлөл ихтэй бол төсөл хэрэгжүүлэгч нь БОНБУ-ний тайлан буюу Байгаль орчин нөлөөлөл байдлын нарийвчилсан үнэлгээ /БОННУ/ хийнэ.
2. Хэрэв нөлөөлөл хөнгөн буюу бага бол төсөл хэрэгжүүлэгч нь БОНБУ-ний маягт буюу байгаль орчны тодорхой бүрдэл хэсгийн талаарх нарийвчилсан дүн шинжилгээ боловсруулна.<sup>2</sup>
3. Хэрэв нөлөөлөл маш бага бол төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн бүртгэлийн маягт бэлтгэнэ.<sup>3</sup> Өмнө нь бичгээр хүргүүлдэг байсан бол одоо цахимаар мэдээлэл оруулдаг болсон байна.

#### Хүснэгт 1. БНХАУ-ын төслийн БОНБУ-ний ангиллын каталогийн загвар<sup>4</sup>

БОНБУ-ний төрөл Төслийн чиглэл ба дэд чиглэлүүд	БОННУ	БОНБУ-ний Маягт	Бүртгэлийн маягт	Байгаль орчны эмзэг байршлын тодорхойлолт
Чиглэл				
Дэд чиглэл				

2018 оны байдлаар БОНБУ хийсэн төслүүдийн 80 хувь нь БОНБУ-ний маягт боловсруулж, 12 хувь нь Бүртгэлийн маягт бөглөж, зөвхөн 8 хувь нь БОННУ-ний тайлан боловсруулсан байна. БОНБУ-ний Маягт нь БОННУ-тэй харьцуулахад цаг бага зарцуулдаг, зардал багатай юм.<sup>5</sup>

Үнэлгээ эрхлэгч компаниудыг тодорхой шалгуурын дагуу үнэлж А болон Б гэсэн 2 ангилалд оруулдаг. Б ангиллын үнэлгээ эрхлэгч нь муж, орон нутгийн төвшний БОННУ, БОНБУ-ний Маягт, Бүртгэлийн Маягт боловсруулах эрхтэй бол А ангиллын үнэлгээ эрхлэгчид нь үндэсний ба орон нутгийн бүхий л үнэлгээ хийх эрхтэй байдаг байна. БОЯ-наас дээрх 2 ангиллын гэрчилгээг 4 жилийн

<sup>2</sup> Тайлангийн маягтыг

[http://www.mee.gov.cn/xxgk/2018/xxgk/xxgk05/202101/t20210104\\_815870.html](http://www.mee.gov.cn/xxgk/2018/xxgk/xxgk05/202101/t20210104_815870.html)

<sup>3</sup> Бүртгэлийн маягтыг эндээс үзэж болно:

[https://www.mee.gov.cn/gkml/hbb/bl/201611/t20161125\\_368260.htm](https://www.mee.gov.cn/gkml/hbb/bl/201611/t20161125_368260.htm)

<sup>4</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзэх боломжтой.

[http://www.mee.gov.cn/gkml/hbb/bl/201707/t20170711\\_417602.htm](http://www.mee.gov.cn/gkml/hbb/bl/201707/t20170711_417602.htm)

<sup>5</sup> Yang, Y. (2020) Reformed Environmental Impact Assessment in China: An Evaluation of Its Effectiveness. Journal of Environmental Protection, 11, 889-908. doi: 10.4236/jep.2020.1110056.

хугацаатай олгодог байна. Ангиллын үндсэн шалгуур нь компанийн үндсэн хөрөнгийн хэмжээ, мэргэжлийн инженер, ажилтнуудын тоо, чанарын хяналтын систем, үнэлгээний ажилд шаардлагатай байр, тоног төхөөрөмж, өмнөх туршлага байдаг байна.

Хуулийн дагуу зөвхөн БОННУ хийхэд олон нийтийн оролцоог хангах нарийвчилсан зохицуулалт үйлчилдэг байна.

#### *Олон нийтийн оролцооны эрх зүйн зохицуулалт*

БНХАУ-д БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах асуудал Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжүүлсэн төслүүдийн шаардлагын хүрээнд анх 1990-ээд оноос тавигдаж эхэлсэн. Улмаар 2002 оны БОНБҮ-ний тухай хуулиар БОННУ хийхэд төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэдийн дунд олон нийтийн асуулга судалгаа хийх зохицуулалтыг орсон байна. Гэвч төсөл хэрэгжүүлэгчээс иргэдэд мэдээлэл өгөх байдал хангалтгүй байсан учраас асуулга судалгаа нь бодит үр дүн багатай, зөвхөн хуульд заасан шаардлагыг биелүүлэх ажил төдий болдог байсан байна.

2006 оны 2 сард “БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах түр арга хэмжээ” буюу түр журмыг БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах газраас баталсан байна. Энэ түр журамд БОННУ-нд иргэдийн оролцох эрх, оролцооны хамрах хүрээ, зохион байгуулалт, хэлбэр, хугацааг тодорхойлсон байна.

#### **2006 оны “БОНБҮ-нд олон нийтийн оролцоог хангах түр арга хэмжээ”-ний агуулга**

- БОННУ-ний тайлан нь “Олон нийтийн оролцоо” гэдэг бүлэгтэй байна.
- БОННУ хийлгэх шийдвэр гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч нь төслийн товч танилцуулга, БОННУ хийх үе шатууд, иргэдийн саналыг авах хүсэлтэй чиглэлүүд, саналаа илэрхийлэх арга замуудыг агуулсан мэдээллийг олон нийтэд танилцуулна.
- Төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч нь БОННУ-ний тайлангийн төслийг эрх бүхий байгууллагад илгээхийн өмнө дараах мэдээллийг олон нийтэд танилцуулна. Үүнд: төслийн тодорхойлолт, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн тойм, авах арга хэмжээ, тайлангийн хялбаршуулсан хувилбартай олон нийт танилцах, нэмэлт мэдээлэл авах арга, хугацаа, олон нийт саналаа илэрхийлэх арга, хэлбэр, хүлээн авах хугацаа
- Олон нийтэд мэдээлэл өгөх арга замуудыг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд: төсөл хэрэгжих орон нутгийн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах, холбогдох мэдээллийг агуулсан зар мэдээ, хэвлэмэл материалыг олон нийтэд чөлөөтэй тараах
- Олон нийтэд тайлангийн төслийн хялбаршуулсан /хураангуй/ хувилбарыг дараах арга замуудаар танилцуулна. Үүнд: тайланг танилцуулах цахим хуудас нээх, хялбаршуулсан тайланг төрийн болон хэвлэл мэдээллийн албан ёсны цахим хуудаснаа нийтлэх
- Хураангуй тайланг нийтэлснээс хойш 10-аас доошгүй ажлын өдөрт олон нийтийн саналыг авах ажлыг зохион байгуулна.
- Байгаль орчны эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хүлээн авсан тухай мэдээллийг өөрийн цахим хуудаснаа мэдээлнэ. Энэ мэдээллийг ажлын 10-аас доошгүй өдөр байршуулж, иргэд, олон нийтээс санал хүлээн авна. Хэрэв төслийн талаар олон тооны санал гарсан тохиолдолд эрх бүхий байгууллагаас нэмэлт хэлэлцүүлэг, асуулга судалгаа, сонгол зохион байгуулж болно.
- Иргэд захидал, факс, мэйлээр болон бусад аргаар саналаа илэрхийлж болно. Саналыг авч үзэхдээ оршин суугаа байршил, ажил мэргэжил, мэргэжлийн мэдлэг,



саналын тодорхой байдал, нөлөөллийн хэмжээ зэрэг хүчин зүйлийг цогцоор нь судална. Иргэдээс санал авахад нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдийг хамруулсан байх ёстой.

- Иргэдээс ирүүлсэн саналыг хүлээн авч нухацтай судлан үзээд хариу тайлбарыг буюу хүлээн авсан эсэхийг тайланд хавсаргана. Хэрэв иргэд, олон нийт уг тайлбарыг хавсаргаагүй эсвэл тайлбар нь хангалтгүй гэж үзсэн бол гомдлоо эрх бүхий байгууллагад гаргаж шалгуулж болно.
- Төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч нь олон нийтийн саналыг авахдаа асуулга судалгааг ашиглаж болох бөгөөд түүний загвар, агуулга энгийн, ойлгомжтой байх ёстой.
- Төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч нь олон нийтээс санал авах зорилгоор танилцуулах хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж болно. Ингэхдээ хурал болохоос ажлын 7 өдрийн өмнөөс зарлан мэдээлнэ. Хурлын тэмдэглэл, дүгнэлтийг ажлын 5 өдрийн дотор бэлтгэнэ.
- Төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч нь олон нийтээс санал авах зорилгоор олон нийтийн сонсгол зохион байгуулж болно. Ингэхдээ сонсгол болохоос ажлын 10 өдрийн өмнө зарлан мэдээлнэ. Сонсголд 15-аас дээш иргэдийн төлөөлөл оролцсон байна. Сонсгол нээлттэй байх бөгөөд уг хэлэх эрхгүй ажилагч нар оролцож болно. Сонсгол хийх дэгийг тусгаж өгсөн. Сонсголын тэмдэглэлийг хянан үзэж гарын үсэг зуруулахаар иргэдийн төлөөлөгчдөд хүргүүлнэ. Хүндэтгэх шалтгаангүйгээр гарын үсэг зурахаас татгалзсан бол сонсголын тэмдэглэлд тэмдэглэнэ.

Энэ журмын хэрэгжилттэй холбоотой цөөнгүй асуудал тулгарч байсан байна. Жишээ нь хэдийгээр энэ журмаар үнэлгээ эрхлэгч нь БОНБУ-ний тайлангийн товч хувилбарыг буюу хураангуйг өөрийн цахим хуудаснаа 10 өдөр нийтэлдэг болсон нь ч уг мэдээлэл нь мэргэжлийн биш, энгийн хүн ойлгоход төвөгтэй эсвэл хэт товчхон байх нийтлэг байсан байна. Ийм учраас иргэд тодорхой санал гаргахад бэрхшээлтэй байсан байна. Түүнчлэн хуулиар иргэд тайлантай бүрэн эхээр нь танилцах боломжгүй байжээ.

2013 оноос БОНБУ-ний хууль болон дээрх журмын хэрэгжилтийг сайжруулах зорилгоор бодлогын өөрчлөлтүүд хийсэн байна. 1989 онд батлагдсанаас хойш нэмэлт өөрчлөлт огт ороогүй байсан Байгаль орчныг хамгаалах хуульд 2013 онд өөрчлөлт оруулсан бөгөөд түүний нэг шалтгаан нь байгаль орчны мэдээллийн ил тод байдал, иргэдийн оролцоог хангах асуудал байсан байна. Улмаар уг хуульд мэдээллийн ил тод байдал, иргэний оролцоо гэдэг шинэ бүлэг нэмж оруулсны дотор БОНБУ- ний ил тод байдлыг зохицуулсан заалтууд багтсан байна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй олон нийтэд танилцуулга хийж, саналыг авах үүрэг
- Эрх бүхий төрийн байгууллага БОННУ-ний тайланг бүрэн эхээр нь олон нийтэд ил тод болгох, хэрэв төсөл хэрэгжүүлэгч олон нийтээс санал авах үүргээ биелүүлээгүй бол энэ үүргээ биелүүлэхийг шаардах үүрэг

Түүнчлэн уг хуульд төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчийн хариуцлагыг сайжруулахын тулд хэрэв иргэд, аж ахуйн нэгж байгаль орчныг хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, хууль зөрчсөн үйлдэл гаргасан бол төрийн мэдээллийн сан буюу энгийнээр хар жагсаалтад оруулж, түүнийг нийтэд ил тод мэдээлэх зохицуулалт оруулсан байна.

2006 оноос оролцооны түр журам хэрэгжиж нэлээд ахиц дэвшил гарсан боловч хэрэгжилттэй холбоотой асуудлууд тулгарч иржээ. Үүнд: үүрэг, хариуцлага тодорхой бус учраас хийдүүлдэг, асуулга судалгааг дүр исгэж хийдэг, олон нийтийн саналыг боловсруулах, хариу өгөх механизм тодорхойгүй, оролцооны үйл явцыг хуурамчаар мэдээлэх, хууль зөрчихөд хүлээлгэх хариуцлага, эдийн засгийн хохирол маш бага учраас хариуцлагаас айдаггүй зэрэг асуудлууд байна.

БОЯ-наас эдгээр асуудлыг шийдвэрлэх, түр журмыг сайжруулах судалгаа, хэлэлцүүлгийн ажлуудыг 2015 оноос хойш хэрэгжүүлж 2018 онд түр журмыг шинэчлэн батлахдаа дараах асуудалд ихээхэн анхаарсан байна. Үүнд

- Олон нийтийн оролцооны үйл явц, үр дүнгийн зөв зохистой байдлыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
- Төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийг нэн тэргүүнд анхаарч саналыг авахын зэрэгцээ сонирхсон олон нийт оролцох боломжтой байх
- Мэдээлэл хүргэх 3 төрлийн арга замыг тодорхой заах: интернэт, сонин, зарлалын самбар
- Олон нийтийн санал юунд чухал болохыг тодорхой болгох
- Асуулга судалгаагаар санал авах арга зүйг сайжруулах
- Олон нийтийн саналын хүлээн авах эсэх, энэ талаар хариу мэдээлэх механизмыг тодорхой болгох
- Оролцооны журмыг зөрчсөн этгээдийн хүлээх хариуцлагыг чангаруулах
- Оролцооны үйл ажиллагаанд ашиглах удирдамж, маягтуудыг боловсруулах

2018 онд батлагдсан оролцооны журмын дагуу БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах үндсэн дарааллыг дараах хүснэгтэд тоймлон танилцуулав.<sup>6</sup> БОННУ хийх явцад иргэдээс санал авах, шаардлагатай бол хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулах түр журмын зохицуулалтууд хэвээр үйлчилж байгаа учраас энэ хүснэгтэд давтаж оруулаагүй болно.

<b>БОННУ хийх шийдвэр гарсны дараа</b>
<p>Төсөл хэрэгжүүлэгч нь өөрийн цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн цахим хуудас эсвэл орон нутгийн удирдлагын цахим хуудаснаа дараах мэдээллийг нийтэлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн суурь мэдээлэл: төслийн нэр, байршил, гол үйл ажиллагаа</li> <li>2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, холбоо барих хаяг</li> <li>3. Үнэлгээ эрхлэгчийн нэр</li> <li>4. Саналаа илэрхийлэх маягыг хаанаас татаж авч болох тухай</li> <li>5. Саналын хуудсаа хэрхэн илгээх тухай</li> </ol> <p>Санал авах хуудасны маягыг яамнаас батална.</p>
<b>БОННУ-ний тайлангийн төсөл боловсруулж дууссаны дараа</b>
<p>Төсөл хэрэгжүүлэгч дараах мэдээллийг олон нийтэд мэдээлнэ:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Үнэлгээний тайлангийн төсөлтэй хаанаас танилцаж болох тухай</li> <li>2. Саналаа хэнд хүргүүлэх тухай</li> </ol>

<sup>6</sup> Журмыг бүрэн эхээр нь эндээс уншиж болно.  
[https://www.mee.gov.cn/xxgk2018/xxgk/xxgk02/201808/t20180803\\_629536.html](https://www.mee.gov.cn/xxgk2018/xxgk/xxgk02/201808/t20180803_629536.html)

3. Саналын хуудас татаж авах хаяг
4. Бичгээр саналаа хэрхэн гаргах тухай
5. Бичгээр саналаа хэзээ гаргах тухай

Ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд олон нийт санал гаргах боломжтой байна. Хэрэв нөлөөллийн талаар олон тооны асуулт, сөрөг саналууд гарсан бол олон нийтийн хэлэлцүүлэг, сонсгол, хурал зэрэг илүү гүнзгий зөвлөлдөх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч зохион байгуулах ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулахаас 10-аас цөөнгүй өдрийн өмнө зарлан мэдээлж хэлэлцүүлэг, сонсголд оролцох сонирхлоо илэрхийлсэн хүмүүсийг бүртгэх, оролцуулах шаардлагатай хүмүүсийг урих ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг дууссанаас хойш 5 өдөрт багтаан хурлын тэмдэглэлийг бэлтгэж олон нийтэд цахимаар ил тод болгох ёстой. Хэлэлцүүлэг, сонсголыг зохион байгуулахдаа холбогдох орон нутгийн захиргааны байгууллагаас зөвлөмж, дэмжлэг авч болно.

Төсөл хэрэгжүүлэгч олон нийтийн гаргасан саналыг анхааралтай шинжлэн үзэж дараах агуулгын хүрээнд тайлан мэдээлэл бэлтгэнэ. Үүнд:

1. Олон нийтийн оролцоог хангах үйл явц, цар хүрээ, авсан арга хэмжээ
2. Саналуудын хэрхэн цуглуулж, дүн шинжилгээ хийсэн тухай
3. Олон нийтийн саналын дагуу авсан арга хэмжээ, хариу тайлбар

Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ-ний тайлангийн төслийг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхийн өмнө түүнийг бүрэн эхээр нь, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийн хамтаар өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна.

**Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайлангийн төсөл, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийг хүлээн авсны дараа**

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:

1. БОННУ-ний тайлан бүрэн эхээрээ
2. Олон нийтийн оролцооны тайлан мэдээлэл
3. Олон нийт саналаа хэрхэн гаргах тухай

Эрх бүхий байгууллага уг мэдээллийг ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд нээлттэй байлгана.

**Эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хэлэлцээд дүгнэлт гаргахын өмнө**

Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний эцсийн тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:

1. Төслийн нэр ба байршил
2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
3. Үнэлгээ эрхлэгчийн нэр
4. Төслийн хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа, байгаль орчны гол нөлөөлөл, хариу арга хэмжээ
5. Төсөл хэрэгжүүлэгчийн олон нийтийн оролцоог хангах талаар явуулсан үйл ажиллагаа
6. Санал, хүсэлт хэрхэн гаргах тухай

Ажлын 5-аас цөөнгүй өдрийн хугацаанд мэдээллийг ил тод байлгана. Энэ мэдээллийн зэрэгцээ олон нийт болон төсөл хэрэгжүүлэгчид хэрэв хүсэлт гаргавал олон нийтийн сонсгол зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдэнэ.

Эрх бүхий байгууллага нь олон нийтийн саналыг авах хуулийн шаардлагыг биелүүлсэн эсэхийг шалгаж, олон нийтийн саналыг нарийвчлан авч үзнэ. Хэрэв шаардлага хангахгүй бол төслийг буцаана.

**Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний тайланг хэлэлцээд дүгнэлт гаргасны дараа**

Дүгнэлтийг өөрийн цахим хуудаснаа байршуулна. Мөн энэ талаар захиргааны гомдол гаргах, авч хэлэлцэх талаарх мэдээллийг байршуулна.

2018 шинэчлэгдсэн түр журамд оролцооны хэрэгжилтийг хангах чиглэлд онцгой анхаарсан байна. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэгч нь олон нийтийн оролцоог хангах ажлын төлөвлөгөө боловсруулж, түүний дагуу тодорхой арга хэмжээг хэрэгжүүлж, тайланд дэлгэрэнгүй тайлан мэдээлэл оруулдаг болсон.
- Эрх бүхий төрийн байгууллагад баримт бичгийг хүлээн авсан даруй олон нийтэд мэдээлэх үүрэг хүлээлгэж хариуцлагыг нэмэгдүүлсэн.
- Эрх бүхий байгууллага оролцооны явцад хяналт тавих, олон нийтээс санал гомдол хүлээн авдаг болсноор оролцооны асуудалд илүү анхаарах болсон.
- Хууль бүс болон нотлох баримт дутуу байдалд хариуцлага тооцох механизм буюу тайланг буцааж оролцоог хангуулах, хууль зөрчсөн, хуурамч мэдээлэл өгсөн бол хар жагсаалтад бүртгэх зохицуулалт орсон.

Нөгөө талаас бизнесийн орчныг дэмжих зорилгоор хэд хэдэн зүйлд анхаарсан байна. Үүнд:

- Олон нийтээс санал бага гарсан байгаль орчны сөрөг нөлөөлөл багатай төслүүдийн олон нийтийн оролцооны үйл явцыг хялбар, шуурхай болох
- Байгаль орчны асуудалд огт хамааралгүй асуудлаар гаргасан саналыг тайланд тусгахгүй байх зохицуулалт орсон байна.

Түүнчлэн холбогдох байгууллагуудаас журмыг хэрэгжүүлэхэд ашиглах баримт бичгийн загвар, маягтуудыг боловсруулж танилцуулсан байна. Үүнд: олон нийтийн оролцооны тайлангийн нийтлэг загвар, санал авах хуудасны маягтыг дурдаж болно.

*Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

БНХАУ-ын хувьд БОНБУ-ний хууль, олон нийтийн оролцоонд холбогдох журмаа баталснаас хойш хуулийн хэрэгжилтийг хангах талаарх бэрхшээлүүд нь Монгол улсын хувьд маш ижил төстэй байна. БОНБУ-ний тогтолцоогоо шинэчилж боловсронгуй болгох чиглэлээр БНХАУ нь сүүлийн жилүүдэд дорвитой алхмууд хийж, бүс нутагтаа тэргүүлэх стандартыг нэвтрүүлсэн гэдгийг харьцуулсан судалгаа харуулж байна.<sup>7</sup>

БНХАУ-ын хувьд Монгол улсын БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах бодлогод ач холбогдолтой дараах үндсэн туршлагууд байна /Хоёр улсын харьцуулалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү/. Үүнд:

- БОНБУ-ний тогтолцоо нь Барууны загвартай буюу “Мэргэжлийн зөвлөл”-ийн Зөвлөлтийн системээс ялгаатай. Төр нь үнэлгээний тайланд дүн

<sup>7</sup> Thiri Shwesiin Aung, Thomas B. Fischer, and Shengji Luan. 3/2020. “Evaluating environmental impact assessment (EIA) in the countries along the belt and road initiatives: System effectiveness and the compatibility with the Chinese EIA.” Environmental Impact Assessment Review, 81, Pp. 106361

шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг явцуу үүрэгтэй биш үнэлгээний үйл явцад хяналт тавих, санал хүсэлт хүлээн авах, олон нийтийг мэдээллээр хангах оролцоотой байна.

- БНХАУ-д үнэлгээний мэдээллийг олон нийтэд зарлан мэдээлэх, санал авах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг журмаар БОННУ хийх дүгнэлт гарахаас тайланг батлах дүгнэлт гарч хэрэгжих хүртэлх үе шат тус бүрээр үүрэгжүүлж тодорхой зохицуулсан бол Монгол улсын хувьд ерөнхий, эрх олгосон байдлаар зохицуулсан байдаг.
- БНХАУ-д БОННУ-ний тайлангийн төслийг хүлээн авч шийдвэр гаргахын өмнө бүрэн эхээр нь олон нийтэд ил тод болгож, олон нийт, иргэд танилцаж, саналаа хүргүүлэх боломж олгодог бол Монгол улсад зөвхөн тайлан батлагдсаны дараа холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх, Байгаль орчны мэдээллийн санд хэсэгчилж мэдээлэл оруулах зохицуулалт үйлчилж байна. Шийдвэр гаргахын өмнө тайлангийн төсөлтэй бүрэн эхээр нь танилцах боломж олгох нь олон нийтийн оролцоо, хяналтыг хангах маш чухал арга зам юм.
- БНХАУ-д БОНБУ-ний ангилалд үндэслэн үнэлгээнд тавигдах шаардлагуудыг ялгаатай тодорхойлж, ингэхдээ БОННУ хийхэд олон нийтийн оролцоог хангах шаардлага тавьдаг. Ингэснээр төрийн байгууллагын ачаалал буурч, сөрөг нөлөөлөл ихтэй төслүүдэд илүү ач холбогдол өгч, хяналт тавих боломж нэмэгддэг байна. Монгол улсын хувьд Ерөнхий үнэлгээний дүгнэлтээр БОННУ хийх шаардлагатай эсэхийг тодорхойлдог бөгөөд хэмжээ, сөрөг нөлөөллийн цар хүрээгээр маш их ялгаатай олон төслүүдийг ангилсан зохицуулалт байхгүй байна. Нөгөөтээгүүр, Монгол улсын хувьд БОННУ хийх нь тодорхой төсөл боловч Төлөв байдлын үнэлгээг Ерөнхий үнэлгээний дүгнэлтээс өмнө хийдэг зохицуулалттай бол БНХАУ-д Төлөв байдлын үнэлгээ нь БОННУ-ний нэг үе шат болон хэрэгжиж цаг хугацаа, хөрөнгө зардлын хэмнэлттэй, иргэд, оролцогч талуудад ойлгомжтой байдаг байна.
- БНХАУ-д 2006 оны түр журмаар олон нийтийн хэлэлцүүлэг, сонсголын тэмдэглэл олон нийтийн оролцоог хангасан эсэх гол баримт болж байсан бол 2018 оноос үнэлгээний эхнээс дуусах хүртэлх хууль, журамд заасан оролцоог хангах үйл ажиллагааг хэрхэн хэрэгжүүлсэн тухай товч тайлан боловсруулж, түүнийгээ олон нийтэд ил мэдээлэх шаардлага тавьсан байна. Монгол улсын хувьд баг, хорооны ИНХ-аар үнэлгээний тайланг хэлэлцсэн протокол, хуралдааны тэмдэглэлийг тайланд хавсаргах шаардлага тавьдаг. Тайлан нь оролцоог хангах үйл явц хуулийн дагуу, үнэн зөв явагдсан эсэхэд хяналт тавих, олон нийт, иргэдийн саналыг хэрхэн хүлээн авч, боловсруулалт хийж, үнэлгээнд тусгасан эсэх талаарх мэдээллийг авах боломж олгож байгаараа давуу талтай байна.
- БНХАУ-д үнэлгээ эрхлэгчийн хариуцлагын асуудалд анхаарч нэгдүгээрт үнэлгээ эрхлэгчдийг байгууллагын чадавхаар үнэлж ангилах, түүнд үндэслэн үнэлгээ хийх боломжтой төрөл, төвшин тогтоох, хоёрт зөрчил гаргасан үнэлгээ эрхлэгчийг олон нийтэд зарлах буюу хар жагсаалтад оруулах арга хэмжээ авч байна.

- Журмаар үнэлгээ эрхлэгч нь олон нийтийн асуулгаар иргэдээс асуулт, санал их гарсан бол сэдэвчилсэн хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулж, ингэхдээ холбогдох төвшний орон нутгийн удирдлагатай хамтран ажиллаж болно гэж заасан байна. Монгол улсын хувьд БОННУ хийж буй бүхий л төслүүдийн үнэлгээг баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлэх шаардлага тавьдаг. БНХАУ-д 2006 оны түр журмаар хэлэлцүүлэг, сонсголын ирцийг доод тал нь 15 хүнээр тогтоож, хурлын тэмдэглэл, оролцогчдын гарын үсгийг тайланд хавсаргах шаардлагатай байсан бол 2018 үүнийг өөрчилж хуралдааны тэмдэглэлийг тухай бүрд нь олон нийтэд цахимаар ил тод болгох замаар хуралд хэн оролцсон, яаж зохион байгуулагдсаныг иргэд, оролцогч талууд хяналт тавих боломжтой болгосон байна. Өөрөөр хэлбэл мэдээллийг тухай бүрд нь ил тод болгож олон нийтээс хяналт тавих боломж олгох шийдлийг хэрэгжүүлж байна. Монгол улсын хувьд хурлын протокол, тэмдэглэлийг тайланд хавсаргах шаардлага тавьдаг бөгөөд 2021 оны 5 сараас эдгээрийг Байгаль орчны мэдээллийн санд батлагдсан БОННУ-ний мэдээллийн хамтаар байршуулж эхэлсэн байна.

## Оросын Холбооны Улс

### БОНБУ-ний тогтолцоо

ОХУ-ын Үндсэн хуульд хүн эрүүл таатай орчинд амьдрах эрх, байгаль орчны тухай болон байгаль орчинд учруулсан хохирлын тухай мэдээлэл авах эрхтэй гэж заасан байна.<sup>8</sup>

БОНБУ-ний асуудлыг зохицуулах гол эх сурвалжууд нь 2002 онд батлагдсан ОХУ-ын Байгаль орчныг хамгаалах хууль, 1995 онд батлагдсан Экологийн экспертизийн тухай хууль, 2000 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх тухай журам юм.<sup>9</sup>

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж буй үйл ажиллагааг нөлөөллийн хэмжээгээр нь их, дунд, бага, маш бага гэсэн 4 бүлэгт ангилж төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчны үүрэг хариуцлагыг ялгаатай байна гэж заасан. 2020 оны 12 сард ОХУ-ын Засгийн газраас дээрх ангиллыг илүү нарийвчилсан журмыг баталсан бөгөөд сөрөг нөлөөлөл багатай бүлэгт хамаарах төслүүдийн хувьд байгаль орчны зөвшөөрөл олгох шат дамжлагыг бууруулна гэсэн бодлого баримталж байна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд зааснаар байгаль орчинд шууд ба шууд бусаар сөрөг нөлөөлөл үзүүлэх аливаа төрлийн үйл ажиллагаанд БОНБУ хийх ёстой. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх журмын хавсралтаар БОНБУ зайлшгүй хийлгэх шаардлагатай 33 төрлийн үйл ажиллагааг тодорхойлсон боловч нарийвчилсан шалгуур үзүүлэлт байхгүй байна. Үүний улмаас БОНБУ нь маш өргөн хүрээнд ижил аргачлалаар хийгддэг гэдэг шүүмжлэл байдаг байна. Байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх журамд зааснаар нөлөөлөл ихтэй буюу 1-р ангиллынхаас бусад төслүүдийн үнэлгээг байгаль орчны муж, орон нутгийн төрийн байгууллагууд зохион байгуулж болно.

ОХУ-д төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчны үнэлгээ эрхлэгч компанитай хамтран үнэлгээний тайланг бэлтгэдэг. Энэ тайланг холбооны болон муж, орон нутгийн төрийн эрх бүхий байгууллагын мэргэжлийн зөвлөл хянан үзэж дүгнэлт гаргадаг. Үнэлгээг хийхэд олон нийтийн оролцоог хангах хариуцлагыг төсөл хэрэгжүүлэгч тал болон орон нутгийн удирдлагын байгууллага хүлээдэг. Мэргэжлийн зөвлөлийн хувьд хянан шалгах, мэргэжлийн дүгнэлт гаргах үүрэг хүлээнэ. Мэргэжлийн бүрэлдэхүүн, чиг үүрэг, мэргэжилтэнд тавигдах шалгуур, ажлын хөлс зэргийг хууль, журмаар зохицуулсан байна.

### Хүснэгт 2. ОХУ дахь БОНБУ-ний үе шатууд

I үе шат	II үе шат	III үе шат
Захиалагч буюу үнэлгээ эрхлэгч БОНБУ хийлгэх хүсэлт, холбогдох бичиг баримтыг ОХУ-ын Байгалийн	Төсөл хэрэгжүүлэгч БОНБУ-ний мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгүүлнэ.	Байгалийн нөөц, экологийн яам, түүний муж, орон нутгийн байгууллагын дэргэдэх Мэргэжлийн зөвлөлөөр үнэлгээний

<sup>8</sup> Эндээс дэлгэрэнгүй уншиж болно: <http://www.constitution.ru/10003000/10003000-4.htm>

<sup>9</sup> Бүрэн эхээр нь эндээс уншиж болно: <https://rpn.gov.ru/activity/services/28159/>

нөөц, экологийн яаманд хүргүүлнэ.		тайланг хянан үзэж дүгнэлт гаргана.
Үнэлгээ хийлгэж буй тухай олон нийтэд зарлан мэдээлж, санал хүлээн авна. Оролцогч талууд, иргэдтэй уулзалт хийнэ.	Үнэлгээний тайлангийн төслийг хэлэлцүүлэх Олон нийтийн сонсгол зохион байгуулна.	
Байгаль орчны төлөв байдал, нөлөөллийн урьдчилсан тойм судалгаа хийнэ.	Үнэлгээний тайлангийн эцсийн хувилбарыг төсөл хэрэгжүүлэгч холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	
Эдгээрийн үндсэн дээр Ажлын даалгавар боловсруулна.		

### *Олон нийтийн оролцооны зохицуулалт*

Байгаль орчны нөлөөлөх байдлыг үнэлэх журамд зааснаар олон нийтийн оролцоог үнэлгээ эхлэх үе шатнаас эхлээд бүхий л үе шатанд хангах ёстой. Дараах хүснэгтэд өнөөдрийн байдлаар оролцоог зохицуулж буй журмыг танилцуулав.

<p><b>БОННУ хийх шийдвэр гарсны дараа</b></p> <p>Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ хийх Ажлын даалгаврын төслийг боловсруулна. Үүний дараа төсөл хэрэгжүүлэгч нь холбооны, мужийн, орон нутгийн хэмжээний сониноор дамжуулан Ажлын даалгаврын төслийн тухайд олон нийтээс санал авах тухай олон нийтэд зар мэдээ хүргэх ёстой. Үүнд дараах мэдээллийг багтаана.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөсөн үйл ажиллагааны нэр, зорилго, байршил;</li> <li>- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, хаяг;</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийх хугацаа;</li> <li>- Олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг бүхий байгууллага;</li> <li>- Олон нийтийн хэлэлцүүлгийн хэлбэр (санал асуулга, сонсгол, анкет судалгаа гэх мэт), санал гаргах арга, хэлбэр</li> <li>- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх Ажлын даалгавартай танилцах арга, хугацаа, байршил;</li> <li>- Бусад мэдээлэл.</li> </ul> <p>Ажлын даалгаврын төслийг нийтэд мэдээлснээс хойш 30 хоногийн дотор иргэд санал, хүсэлтээ илгээж болно. Олон нийтээс ирсэн саналыг харгалзан үзэж Ажлын даалгаврын эцсийн хувилбарыг боловсруулна.</p>
<p><b>БОННУ-ний тайлангийн төслийг илгээхийн өмнө</b></p> <p>Тайлангийн төслийн талаар олон нийтийн сонсгол зохион байгуулах ёстой.</p> <p>Төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн захиргаанд хүсэлт хүргүүлнэ. Орон нутгийн захиргаа сонсгол зохион байгуулах тогтоол гаргана. Нийтийн сонсгол зохион байгуулах огноо, байршлын тухай зар мэдээ сонсгол зохион байгуулагдахаас 30-аас доошгүй хоногийн өмнө албан ёсны эх сурвалжуудад /сонин/ нийтлэгдсэн байх ёстой. Төсөл хэрэгжүүлэгч үнэлгээний тайлангийн төслийн мэдээллийг олон нийтэд 30 доошгүй хоногийн турш нээлттэй байршуулах ёстой.</p>



Орон нутгийн захиргаа сонсголд оролцох хүсэлтэй иргэдийг бүртгэх /30 хоногийн турш/, олон нийтийн сонсгол зохион байгуулах, сонсголын тэмдэглэлийг бэлтгэх үүрэгтэй /5 хоногт багтаана/. Сонсгол зохион байгуулах зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцна.

Тэмдэглэлийг төсөл хэрэгжүүлэгч, орон нутгийн удирдлага, олон нийт гэсэн гурван талын төлөөлөл нягталж гарын үсэг зурдаг. Дараа нь түүнийг бусад баримт бичгийн хамт байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хавсаргана.

Сонсгол дээр ямар ч шийдвэр гаргахгүй бөгөөд төслийн талаар иргэдэд мэдээлэл өгөх, тэдний санал хүсэлтийг хүлээн авах явдал гэдгийг онцолдог.

Хуулийн дагуу сонсгол дууссанаас хойш 30 хоногийн дотор иргэд бичгээр санал, хүсэлтээ илгээж болно.

#### **Үнэлгээний тайланд тусгах асуудлууд**

Үнэлгээний журмын дагуу тайланд дараах мэдээлэл орсон байх ёстой.

12. Үнэлгээний тайланг бэлтгэх явцад олон нийтээс санал авах ажлын тайлан:

12.1. Олон нийтээс санал авах арга, цаг хугацаа, хэлбэрийг зэргийг зарлан мэдээлсэн арга

12.2. Санал авах үйл ажиллагаанд оролцсон иргэдийн овог, нэр, байгууллагын нэр (хэрэв байгууллага төлөөлж оролцсон бол), түүнчлэн эдгээр байгууллагын хаяг, утасны дугаар эсвэл хэлэлцүүлэгт оролцогчдын хаяг, утасны дугаар

12.3. Санал гаргасан иргэдийн хөндсөн асуудал, танилцуулга хийсэн бол түүний хувь, олон нийтийн сонсголын тэмдэглэл (хэрэв сонсгол зохион байгуулсан бол).

12.4. Хүлээн авсан санал, зөвлөмж, үүнд олон нийт, орон нутгийн засаг захиргаа, төсөл хэрэгжүүлэгчийн хооронд гарсан саналын зөрүүний талаарх дүн шинжилгээ

12.5. Олон нийтийн хэлэлцүүлэг, санал авах ажлын үр дүнд үндэслэсэн дүгнэлт.

12.6. Олон нийтийн саналын алийг нь харгалзан үзсэн, харгалзан үзээгүй бол ямар шалтгаанаар гэдгийг тайлбарласан тэмдэглэл

12.7. Үнэлгээний бүх үе шатанд оролцогч талуудад илгээсэн холбогдох мэдээлэл

Түүнчлэн, тайланд түүний техникийн бус хураангуйг хавсаргах ёстой байна.

2020 оны 12 сарын 1-нд ОХУ-ын Байгалийн нөөц, экологийн яамны сайд “БОНБУ-ний материалд тавигдах шаардлагын тухай” тушаал гаргаж, үүнд үнэлгээний үе шат бүр дэх оролцоог хангахтай холбоотой үйл ажиллагааны нарийвчилсан зохицуулалтыг тусгасан байна. Үнэлгээнд холбогдох зар мэдээг хүргэх төрийн ба төсөл хэрэгжүүлэгчийн цахим сувгууд /өмнө зөвхөн сонин хэвлэл байсан/, мэдээллийн агуулга, хэлэлцүүлэг зохион байгуулах үүрэг, хариуцлага зэрэг асуудлыг нарийвчлан үзсэн байна.

Олон нийтийн зар мэдээний загвар, олон нийтээс санал авах маягт, нийтийн сонсголын тэмдэглэл, оролцогчдын бүртгэлийн маягт зэрэг оролцоотой холбоотой хэрэглэгдэхүүнийг муж, орон нутгийн холбогдох байгууллагаас боловсруулж гаргасан байдаг.

Нийтийн сонсголыг хэрхэн зохион байгуулах талаар гарын авлага, удирдамж, зөвлөмж эх сурвалж их байна. Үнэлгээ эрхлэгч компаниудын танилцуулгад нийтийн сонсголыг үр дүнтэй зохион байгуулах чадавх, туршлагынхаа талаар онцлон дурдсан байна.

Оролцоог хангах гол арга хэрэгсэл нь үнэлгээний тайлангийн төслийг хэлэлцүүлэх нийтийн сонсгол болдог нь харагдаж байна. Сонсголын үр дүнг сонсголын тэмдэглэл байдлаар бэлтгэж БОНБУ-ний тайланд хавсаргах ёстой боловч дэлгэрэнгүй тайлан мэдээлэл бэлтгэх шаардлага байхгүй байна.

Хуулиар үнэлгээний эхний үе шатанд буюу ажлын даалгавар боловсруулах үед компаниуд хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой. Гэвч төсөл хэрэгжүүлэгчид энэ талаар олон нийтэд мэдээлэхдээ хойрго бөгөөд сонинд товч зар мэдээ хэвлүүлэх байдлаар хуулийн шаардлагыг биелүүлсэн болдог гэж үзсэн байна. Үнэлгээний явцад төсөл хэрэгжүүлэгчид болон үнэлгээ эрхлэгчид эрх ашиг нь хөндөгдөж буй иргэдтэй зөвлөлдөх, санал авах ажлыг орхигдуулдаг. Үүний улмаас тайлангийн төслийг хэлэлцэх нийтийн сонсгол хийх үед ширүүн хэрүүл маргаан гарах нь элбэг тохиолддог байна.<sup>10</sup>

Хуулиар ТББ-ууд сайн дурын БОНБУ хийж, нийтийн сонсгол зохион байгуулж болно. Ингэхийн тулд орон нутгийн удирдлагад өргөдөл гаргаж, олон нийтэд мэдээлэл хүргэх ёстой. Гэхдээ энэ нь зөвхөн сайн дурын шинж чанартай, албан бус үйл ажиллагаа байдаг.

Судлаачдын үзсэнээр БОНБУ хийх төслийн ангилал нарийвчлал багатай, маш олон төслийг хамруулах боломжтой учраас бодит байдал дээр маш их хийдэл гардаг байна. Томоохон төслүүдийн хувьд хуульд заасан шаардлагуудын дагуу олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг бол ихэнх дунд, жижиг төслүүдийн хувьд хуулийн хэрэгжилт хангалтгүй байдаг байна.

#### *Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

ОХУ-ын БОНБУ-ний тогтолцоо нь Мэргэжлийн зөвлөл буюу экологийн экспертиз гэдэг Зөвлөлтийн үеийн загвараа хадгалсан байна. Гэхдээ нийгмийн хэрэгцээ, олон нийтийн шаардлагаар зарим өөрчлөлтийг аажмаар хийж, ингэхдээ олон нийтийн санал авах, хэлэлцүүлэг хийх зохицуулалтыг багтаасан байна. Төр нь Мэргэжлийн зөвлөлөөр дамжуулж нь үнэлгээг хүлээн авч дүн шинжилгээ хийх үүрэгтэй энэ загвар хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан улсуудад нийтлэг хэрэгжиж байна. Монгол улсын хувьд ч гэсэн энэ загвар буюу БОАЖЯ зөвхөн үнэлгээний тайланд дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг байдал хэрэгжиж байна.

ОХУ-д БОНБУ-ний стратегийн, хуримтлагдах, нарийвчилсан төрлүүдийг хуулиар зааглаж зохицуулаагүй, батлагдсан тайлангийн ил тод байдлыг хангах талаар нарийвчилсан зохицуулалт алга байна. Тухайлбал, төрийн байгууллагын цахим хуудсанд батлагдсан БОНБУ-ний жагсаалт байгаа боловч дэлгэрэнгүй мэдээлэл оруулдаггүй байна. Харин хууль, журмын дагуу Ажлын даалгаврын төсөл, үнэлгээний тайлангийн төсөлд олон нийтээс санал авах үйл ажиллагаатай

---

<sup>10</sup> Nenasheva, Marina; Bickford, Sonja H.; Lesser, Pamela; Koivurova, Timo; Kankaanpää, Paulav 2015. Legal tools of public participation in the Environmental Impact Assessment process and their application in the countries of the Barents Euro-Arctic Region.

холбоотой төсөл хэрэгжүүлэгчийн олон нийтэд нээлттэй болгосон мэдээлэл их байна.

ОХУ-ын хувьд Монгол улсын БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах бодлогод ач холбогдолтой дараах үндсэн туршлагууд байна. Үүнд:

- ОХУ-д БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах гол арга зам нь үнэлгээний тайлангийн төслийг хэлэлцүүлэх Олон нийтийн сонсгол байна. Сонсголыг төсөл хэрэгжүүлэгчийн хүсэлтээр холбогдох муж, орон нутгийн төрийн байгууллага зохион байгуулдаг байна. Сонсгол зохион байгуулах зар мэдээлэл, түүний хэлбэр, агуулга, хугацаа, үнэлгээний төслийн мэдээлэлтэй танилцах боломж, сонсгол зохион байгуулсан дэлгэрэнгүй тайлан боловсруулж, олон нийтэд тодорхой хугацаанд ил тод байршуулах шаардлага тавьж хэрэгжилтийг хангахыг зорьж байна. Төслийн үнэлгээнд холбогдох оролцогч талуудын гаргасан эерэг, сөрөг бүхий л мэдээллийг тайланд баримтжуулах шаардлагатай байна. Монгол улсын хувьд бие даасан сонсгол зохион байгуулахгүйгээр баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж, хурлын “дэмжсэн” тогтоол, товч тэмдэглэлийг хавсаргах зохицуулалттай. Энэ нь үнэлгээнд дүн шинжилгээ хийж байгаа шинжээч, Мэргэжлийн зөвлөл оролцоог хангах талаарх төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгчийн авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, оролцооны явц, үр дүнгийн талаар мэдээлэл авах боломжгүй байна гэсэн үг юм.
- ОХУ-д үнэлгээ хийх төслийн ангиллыг нарийвчлах, ангиллаас хамаарч үнэлгээний цар хүрээ, бусад шаардлагуудыг ягаатай зохицуулах алхам хийгдэж байна. Монгол улстай нэгэн адилаар Ковид цар тахлын улмаас төслийн үнэлгээг хийхэд бэрхшээлтэй асуудлууд тулгарч аж ахуйн нэгжүүдэд хүндрэл учирч байгаа нь үнэлгээний ангилал, зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээг нэмэгдүүлсэн байна. Жишээ, 2021 оны 12 сарын 31-нийг хүртэл олон нийтийн санал авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагааг цахим, зайн хэлбэрт шилжүүлсэн байна.

## Бүгд Найрамдах Солонгос Улс

### *БОНБУ-ний тогтолцоо*

1977 онд БНСУ-ын Байгаль хамгаалах тухай хууль шинэчлэн батлагдсанаар БОНБУ хийх эрх зүйн суурь тавигджээ. Уг хуулийн 5-р зүйлд хот төлөвлөлт, аж үйлдвэрийн бүтээн байгуулалт, эрчим хүчний төсөл зэрэг үндэсний хэмжээний төслийг хэрэгжүүлэхээс өмнө Эрүүл мэнд, нийгмийн харилцааны сайдтай зөвлөлдөх шаардлагатай гэж заасан байна. Ингэснээр Эрүүл мэнд, нийгмийн харилцааны яамнаас хөгжлийн төсөл, хөтөлбөртэй холбоотой үүсэх байгаль орчны бохирдлын асуудалд оролцох боломж анх бий болсон байна. Гэхдээ байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх, олон нийтийн оролцоог хангах зэрэг шаардлага хараахан тусгагдаагүй байжээ.

БНСУ-ын эдийн засгийн хурдтай хөгжлийн улмаас 1980-аад оноос байгаль орчны бохирдлын асуудал хурцадсан. Энэ үеээс Байгаль орчны албыг шинээр байгуулж, улмаар 1986 онд Байгаль орчныг хамгаалах хуулиа шинэчилжээ. Энэ хүрээнд хувийн секторын үйл ажиллагаа, томоохон төслүүд нэмэгдсэнтэй холбоотой байгаль орчны үнэлгээ, хяналтын хүрээг өргөжүүлсэн байна.<sup>11</sup>

1990 онд Байгаль орчны газрыг Байгаль орчны яам болгон томсгон зохион байгуулсан байна. Мөн Байгаль орчны урт хугацааны бодлогын тухай хууль батлагдаж, үүнд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тодорхойлолт, үнэлгээний дараах менежмент, үнэлгээг хийх явцад оршин суугчдын саналыг авах зохицуулалтыг тусгажээ.

Улмаар 1993 онд БОНБУ-ний тухай хууль батлагдаж үндэсний БОНБУ-ний тогтолцоо бүрэлдэх боломж бүрдсэн байна. 1997 онд Солонгосын байгаль орчны хүрээлэн /Korea Environment Institute (KEI)/ гэдэг БОНБУ-ний тайланд мэргэжлийн хяналт шинжилгээ хийх зорилготой шинэ байгууллагыг байгуулсан. 2000 оноос төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн шатны байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг зэрэгцээ төслийн бүтээн байгуулалтын үе шатанд үүсэх нөлөөллийн асуудалд анхаарал хандуулж төслийн байршил, төлөвлөлтийг үнэлэх тусгай зохицуулалт нэвтрүүлж байсан байна.


БНСУ 2012 онд БОНБУ-ний тухай хуулиа шинэчлэн баталсан байна.<sup>12</sup> Уг хуулийн дагуу БНСУ-д Стратегийн нөлөөллийн үнэлгээ /СНУ/, БОНБУ /БОННУ/, бичил БОНБУ гэсэн 3 төрлийн үнэлгээ хэрэгжиж байна. Стратегийн нөлөөллийн үнэлгээ нь засгийн газрын бодлого болон хөгжлийн мастер төлөвлөгөө гэсэн 2 үндсэн чиглэлийн үйл ажиллагаанд хийгдэнэ. БОНБУ нь зам, боомт, дэд бүтэц зэрэг томоохон төслүүдэд хамаарна. Бичил БОНБУ нь тусгай хамгаалалт шаардлагатай бүс нутагт хэрэгжих, БОНБУ-нд хамаарахгүй төслүүдэд хийгдэх хялбаршуулсан, бичил үнэлгээ юм.

### Бүдүүвч 2. БНСУ-ын БОНБУ-ний ангилал

<sup>11</sup> Дэлгэрэнгүйг эндээс уншиж болно. <https://wedocs.unep.org/handle/20.500.11822/9051>

<sup>12</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.

[https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=45064&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=45064&lang=ENG)



Үнэлгээний үйл явцын хувьд төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний ажлын даалгаврыг боловсруулж олон нийтээс санал авна. Үүний дагуу БОЯ болон зөвшөөрөл олгогч холбогдох ажлын даалгаврыг баталдаг. Энэ даалгаврын дагуу төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний тайлангийн төслийг боловсруулна. Төслийн талаарх оршин суугчдын саналыг хүлээн авч, шаардлагатай бол хэлэлцүүлэг уулзалт зохион байгуулна. Тайлангийн эцсийн хувилбарыг БОЯ нь Солонгосын байгаль орчны хүрээлэнгийн шинжээчдийн дүгнэлтийн тусламжтайгаар дүгнэн үзээд саналаа холбогдох зөвшөөрөл олгогч байгууллагад хүргүүлдэг байна.

#### *Стратегийн үнэлгээ ба олон нийтийн оролцоо*

Засгийн газрын бодлогын СНҮ хийхэд хамрах хүрээ хэт өргөн гэдэг үндэслэлээр оршин суугчдын саналыг авах шаардлага байдаггүй. Харин хөгжлийн мастер төлөвлөгөө, засгийн газраас хэрэгжүүлэх төслүүдийн хувьд оршин суугчдын саналыг авах зохицуулалт байдаг.

Нэгдүгээрт, СНҮ-ний хүрээ буюу үнэлгээнд авч үзэх асуудлуудыг тодорхойлсоны дараа төсөл хэрэгжүүлэгч холбогдох орон нутгийн /хот, гун, гү/ төрийн захиргааны мэдээллийн нэгдсэн порталд энэ талаар мэдээлэл оруулж 14-өөс дээш хоногийн хугацаанд олон нийтэд ил тод байршуулж санал авна.

Хоёрдугаарт, СНҮ-ний тайлангийн төслийн товч агуулга, санал авах хугацаа, арга зэрэг мэдээллийг өдөр тутмын ба орон нутгийн сонинд нийтлүүлэх ёстой бөгөөд сонирхсон иргэд доод тал нь 20, дээд тал нь 40 хоногийн хугацаанд уншиж танилцах, саналаа хүргүүлэх боломжоор хангах ёстой.

Гуравдугаарт, хэрэв оршин суугчид хүсэлт гаргавал төсөл хэрэгжүүлэгч нь олон нийтэд танилцуулга хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой.

Дөрөвдүгээрт, иргэдийн саналыг авсаны дараа үр дүн буюу тайланд мэдээллийг нь холбогдох орон нутгийн захиргааны мэдээллийн нэгдсэн порталд 14-өөс дээш хоногийн хугацаанд олон нийтэд нээлттэй байршуулах ёстой.

Өнөөгийн эрх зүйн зохицуулалтаар оролцоог орон суугчдаар хязгаарлаж байна. Түүнчлэн иргэдийн саналыг хэрхэн тусгасан талаар тайлангах шаардлага тавьдаггүй, батлагдсан тайлангийн ил тод байдлын талаар зохицуулалт байхгүй байна.

*Төслийн БОНБУ буюу нарийвчилсан үнэлгээнд оролцоог хангах нь*

Нэгдүгээрт, БОНБУ-ний хүрээ буюу үнэлгээнд авч үзэх асуудлуудыг тодорхойлсоны дараа буюу Ажлын даалгаврын төслийг төсөл хэрэгжүүлэгч холбогдох орон нутгийн /хот, гун, гү/ төрийн захиргааны мэдээллийн нэгдсэн порталд энэ талаар мэдээлэл оруулж 14-өөс дээш хоногийн хугацаанд олон нийтэд ил тод байршуулж санал авна.

Хоёрдугаарт, төсөл хэрэгжүүлэгч нь БОНБУ-г хийх явцад оршин суугчдын саналыг авах ажлыг зохион байгуулна.

Гуравдугаарт, холбогдох орон нутгийн захиргаа БОНБУ-ний тайлангийн төслийг хүлээн авсанаас хойш 10 хоногийн дотор түүний товч агуулга, санал авах хугацаа, арга зэрэг мэдээллийг багтаасан зар мэдээг өдөр тутмын ба орон нутгийн сонинд нийтлүүлэх ёстой бөгөөд сонирхсон иргэд доод тал нь 20, дээд тал нь 60 хоногийн хугацаанд уншиж танилцах, саналаа хүргүүлэх боломжоор хангах ёстой.

Гуравдугаарт, хэрэв оршин суугчид хүсэлт гаргавал төсөл хэрэгжүүлэгч нь олон нийтэд танилцуулга хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой.

Дөрөвдүгээрт, иргэдийн саналыг авсаны дараа үр дүнг нь холбогдох орон нутгийн захиргааны мэдээллийн нэгдсэн порталд 14-өөс дээш хоногийн хугацаанд олон нийтэд ил байршуулах ёстой.

*Бичил БОНБУ хийхэд иргэдийн саналыг хэрхэн авдаг вэ?*

Санал авах зохицуулалт байхгүй.

*Тайлангийн ил тод байдал*

БОНБУ-ний хуулийн 66-р зүйлд БОНБУ-ний тайланг хэвлэн нийтлэх талаар зохицуулахдаа БОЯ хэрэв өөр хуулиар хориглоогүй бол тайланг өөрийн портал сайт дээр нээлттэй тавьж болно гэж заасан. Гэхдээ төсөл хэрэгжүүлэгч нь хуульд заасан үндэслэлээр /төрийн нууц, бизнесийн нууц, төслийн хэрэгжилт/ тайланг бүхлээр болон хэсэгчлэн нийтлэхгүй байхыг хүсвэл БОЯ нийтлэхгүй байх шийдвэр гаргаж болно. Тайлантай холбоотой бусад харилцааг Албаны мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар зохицуудаг байна.

*БОНБУ-ний мэдээллийн систем*

БОНБУ-ний хэрэгжилтийг дэмжих зорилготой мэдээлэл, үйлчилгээний EIA Support System (EIASS) гэдэг онлайн портал бий. Энэ портал нь төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ эрхлэгч, орон нутгийн удирдлага, олон нийтэд зориулсан нээлттэй мэдээллийг агуулдаг. Үүнд СНҮ, БОНБУ, бичил БОНБУ-ний тайлангийн дүгнэлт, үнэлгээний явцын мэдээлэл, үнэлгээтэй холбоотой статистик,

үнэлгээний газарзүйн мэдээлэл, хууль эрх зүйн эх сурвалжууд, судалгааны тайлан, тайлбар толь, үнэлгээ эрхлэгчдийн мэдээлэл зэрэг орсон байна.

БОЯ нь БОНБҮ-ний тодорхой чиглэл, сэдэвт зориулан 50 гаруй журам, удирдамж боловсруулсан байна.

#### *Хариуцлагын механизм*

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлагыг маш тодорхой заасан байна. Тухайлбал, дараах зөрчил гаргавал 2 жил хүртэл хорих буюу 20 сая хүртэлх воны торгуулиар шийтгүүнэ. Үүнд:

- БОНБҮ-ний тайланг боловсруулахдаа өөр тайлангаас хуулбарласан
- Үнэлгээний тайлан, өгөгдлийг боловсруулахдаа буруу дүгнэлт танилцуулга хийсэн
- Үнэлгээний тайланг боловсруулахдаа ашигласан анхдагч суурь өгөгдлийг устгасан

#### *Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

БНСУ-ын хувьд олон нийтийн оролцооноос илүүтэй мэргэжлийн судалгааны байгууллагын дүн шинжилгээ, хяналтад илүүтэй ач холбогдол өгсөн байна. Солонгосын байгаль орчны хүрээлэн БОНБҮ-ний тайланд дүн шинжилгээ хийж дүгнэлтээ Байгаль орчны яаманд хүргүүлдэг төрийн албан ёсны судалгааны байгууллага юм. Тайлангийн талаарх шийдвэрийг яам гаргах боловч техникийн дүн шинжилгээг мэргэжлийн байгууллага бэлтгэж өгдөг нь БОНБҮ-ний үнэ зөв байдал, олон нийт, оролцогч талуудын итгэх байдалд эергээр нөлөөлдөг нь дамжиггүй юм. Монгол улсын хувьд БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн шинжээчид, БОАЖЯ-ны дэргэдэх Мэргэжлийн зөвлөл нь үнэлгээний тайланд мэргэжлийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үүрэгтэй. Үнэлгээ, аудитын хэлтэс нь ажлын ачаалал ихтэй байдаг. Мэргэжлийн зөвлөл нь 10-аас доошгүй гишүүдтэй, сард 1 удаа хуралдах журамтай. Гишүүд нь байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, эдийн засаг, хөгжлийн салбарын холбогдох яам, агентлагууд, мэргэжлийн байгууллагын төлөөлөл байдаг. Тийм учраас Үнэлгээ аудитын хэлтэс, Мэргэжлийн зөвлөл нь маш олон тооны үнэлгээний тайланд нэг бүрчлэн мэргэжлийн нарийвчилсан дүн шинжилгээ хийх цаг хугацаа, хүч хөрөнгө хангалтгүй байдаг.

Төслийн ангиллаас хамаарсан оролцооны шаардлага тавигддаг, олон нийтийн оролцоог иргэдэд зарлан мэдээлэх, баримт бичгийн төсөлтэй танилцах боломжоор хангах, иргэд цахимаар болон бичгээр санал гаргах оролцооны суурь зарчмыг хэрэгжүүлж, хэрэв олон нийт хүсэлт тавьсан тохиолдолд хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулдаг шаталсан, уян хатан зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд нэгдсэн онлайн портал систем, орон нутгийн төрийн байгууллагын хяналт, иргэдийн идэвх, оролцоо, хариуцлагын механизм чухал нөлөөтэй байна.

## Казакстан

### *БОНБУ-ний тогтолцоо*

2007 онд Казакстан улсын Экологийн тухай багц хууль батлагдсан байна. Уг хуулийн 6-р бүлэгт БОНБУ-ний зохицуулалтыг тусгасан байна. Үүнд БОНБУ хийх шаардлага, үе шатууд, үнэлгээ хийх үүрэг хариуцлага, үнэлгээ хийх төслүүдийн ангилал, нөлөөллийн төрлүүд, нөлөөллийн үнэлгээний тайлангийн агуулга болон хавсралт баримт бичгүүдийг тодорхойлсон. Түүнчлэн БОЯ болон орон нутгийн байгаль орчны газраас БОНБУ-нд хийх дүн шинжилгээний журмыг тодорхойлсон байна.

БОНБУ хийх шаардлагатай төслүүдийг Ариун цэврийн тухай хуульд заасан аюулын зэрэгт үндэслэн 4 бүлэгт ангилсан. 1-р бүлэгт хамаарах төслийн үнэлгээний шинжилгээг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, 2, 3, 4-р бүлэгт хамаарах төслүүдийн үнэлгээний шинжилгээг орон нутгийн байгаль орчны асуудал хариуцсан байгууллага хэрэгжүүлэхээр заасан байна.<sup>13</sup> Аль бүлэгт хамаарахаас шалтгаалж шинжилгээний дүгнэлт хийх хугацааг ялгаатай тогтоосон. 1-р бүлгийн төслийн үнэлгээний шинжилгээг ажлын 45 хоногийг дотор, 2-р бүлэг бол 30 хоног, 3, 4-р бүлгийн хувьд 15 хоногт багтаан шинжилгээний дүгнэлтийг гаргах ёстой байна.

### *Олон нийтийн оролцооны зохицуулалт*

2007 оны багц хуулийн 57.1-д байгаль орчны талаарх асуудлаар шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах арга замуудыг заасан байна. Үүнд:

- Нийтийн сонсгол хийх
- Олон нийтийн сайн дурын дүн шинжилгээ хийх
- Олон нийтийн байгаль орчны хяналт хийх
- Мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гаргах явцад санал илэрхийлэх
- Төрийн байгууллагын дэргэдэх олон нийтийн зөвлөлд ажиллах
- Байгаль орчны хууль, журмыг өөрчлөхөд саналаа илэрхийлэх

Хуулиар нийтийн сонсгол заавал хийх ёстой төслүүдийн чиглэлийг тодорхой заасан байна. Улмаар 2016 онд нийтийн сонсгол хийх шаардлагатай аж ахуйн үйл ажиллагааны жагсаалтыг Засгийн газраас баталсан байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь орон нутгийн удирдлагатай хамтран нийтийн сонсгол зохион байгуулдаг. Уг хуульд зааснаар төсөл хэрэгжүүлэгч буюу захиалагч нь нийтийн сонсгол хийхдээ төрийн бус байгууллагыг гэрээний үндсэн дээр татан оролцуулах эрхтэй.

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагууд нь нийтийн сонсгол зохион байгуулахаас 20 хоногийн өмнө интернэтийн болон бусад эх үүсвэрээр дамжуулан сонсголын талаар зарлан мэдээлж, сонирхсон иргэдийг БОНБУ-ний

---

<sup>13</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү. [https://adilet.zan.kz/rus/docs/K070000212\\_](https://adilet.zan.kz/rus/docs/K070000212_)



тайлангийн төсөлтэй танилцах боломжоор хангах ёстой. Энэ зар мэдээний маягтыг БОЯ-наас баталсан байна.

Нийтийн сонсгол зохион байгуулах журмыг байгаль орчныг хамгаалах эрх бүхий байгууллага тогтооно гэж хуульд заасны дагуу 2007 онд БОЯ-наас нийтийн сонсгол хийх журмыг баталж, 2016 онд нэмэлт өөрчлөлт оруулжээ. Үүнд нийтийн сонсголын тэмдэглэл хөтлөх маягт багтаж байна.

Уг журмаар олон нийтээс санал авах үйл ажиллагааг нийтийн сонсгол, олон нийтийн санал асуулга гэсэн 2 төрлийн аргаар зохион байгуулж болно.


Нэгдүгээрт, БОНБҮ-ний төслийн ангиллын 1, 2-р бүлэгт хамаарах төслүүдийн хувьд нийтийн сонсгол зохион байгуулна.

Хоёрдугаарт, 3, 4-р бүлэгт хамаарах төслүүдийн хувьд олон нийтийн санал асуулга явуулна. Асуулгын загвар хуудсыг журамд хавсаргасан байна.

Уг хуулиар төрийн экологийн мэдээллийн санд оруулах мэдээллийн жагсаалтад БОНБҮ-ний материалууд буюу тайлан болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт багтсан байна.

Сүүлийн жилүүдэд Экологийн багц хуулийг шинэчлэх ажил эрчимтэй явагдаж, үүнд БОНБҮ-ний зохицуулалтыг Европын холбоо болон бусад орчин үеийн стандарт шаардлагад нийцүүлэн шинэчлэх ажил хэрэгжсэн. Ийнхүү 2021 оны 1 сард Экологийн шинэ багц хууль батлагдсан.<sup>14</sup> Хуулиар анх удаа БОНБҮ-г 4 ангиллаар ялган үзсэн бөгөөд үнэлгээний төрөл тус бүрд оролцоог хангах шаардлагуудыг тусгажээ.

### Бүдүүвч 3. Казакстан улсын БОНБҮ-ний шинэ ангилал



<sup>14</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү: <https://adilet.zan.kz/rus/docs/K2100000400>

Шинэ хуулиар үнэлгээний үе шат тус бүрийн үйл явцыг маш нарийвчлан тодорхойлж, үүнд олон нийтэд мэдээлэл өгөх, санал авах чиг үүрэг, хугацаа, тайлагналыг тодорхой заасан байна. Үүнд дараах онцлог зохицуулалтууд байна.

- Төрийн болон орон нутгийн байгууллагууд үнэлгээ хийлгэх хүсэлт, түүнтэй холбоотой шийдвэрүүд, олон нийтийн зар мэдээг маш шуурхай /2-5 хоногт/ олон нийтэд цахимаар мэдээлэх үүрэг хүлээсэн.
- Төсөл хэрэгжүүлэгч нь үнэлгээний тайлангийн төслийг БОЯ-нд хүргүүлэхдээ бизнесийн нууцад хамаарах хэсгүүдээ тодорхойлж олон нийтэд мэдээлэхгүй байх хүсэлт хавсаргах, түүнийхээ дагуу холбогдох мэдээллийг хассан тайлангийн хувийг хамт өгөх үүрэгтэй байна. Энэхүү хувийг олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байлгах үүргийг холбогдох төрийн байгууллага хүлээж байна.
- БОЯ үнэлгээний тайлангийн төслийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор, орон нутгийн захиргаа 1 өдрийн дотор цахим хуудаснаа 30-аас доошгүй өдрийн нээлттэй байршуулна. Төсөл хэрэгжүүлэгч нь сонин, радио телевиз, бусад мэдээллийн хэрэгслээр сонсгол болохоос 20 өдрийн өмнөөс олон нийтэд зар мэдээ хүргэх үүрэг хүлээсэн байна. Төрийн ба төрийн бус байгууллагууд, иргэд, сонирхогч олон нийт саналаа бичгээр гаргах бол төрийн болон орон нутгийн холбогдох байгууллагад сонсгол болохоос наад зах нь 3 өдрийн өмнө илгээж болно.
- Эхний сонсголын үр дүнгээс хамаарч хоёрдох удаагийн сонсголыг зохион байгуулж болохоос гадна хэрэв шаардлагатай бол Экспертийн зөвлөлийг томилж ажиллуулах зохицуулалт хийсэн байна.

#### *Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

Казакстан улс нь БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах зохицуулалтыг журмаар биш шинэ хуулиар дэлгэрэнгүй зохицуулсан нь чухал давуу тал болж байна. Түүнчлэн, хуучин Зөвлөлтийн Экологийн экспертиз буюу төрийн Мэргэжлийн зөвлөлөөр үнэлгээг хянан үзэж, дүгнэлт гаргадаг загварыг аажмаар өөрчилж төр ба орон нутгийн байгууллагууд нөлөөллийн үнэлгээний үйл явцад хяналт тавих, иргэдийн оролцоог хангах зохих үүрэг хүлээж оролцдог зохицуулалтыг хэрэгжүүлж байна. Энэ нь үнэлгээний талаарх зар мэдээллийг олон нийтэд хүргэх, тайлангийн төслийн ил тод байдлыг хангах үйл ажиллагааг цахимжуулахад анхаарах, Олон нийтийн сонсголыг үр дүнтэй зохион байгуулах, талуудын зөрчилдөөнийг зохицуулах Экспертийн зөвлөлийн механизмыг шинээр нэвтрүүлэх бодлогоос харагдаж байна.

## Хөгжиж буй ижил төстэй улсуудын туршлага

### Ботсвана

Ботсвана улс нь Өмнөд Африкийн далайд гарцгүй, 2.3 сая хүн амтай жижиг улс юм. Түүнчлэн тус улс нь олон намын тогтолцоо бүхий ардчилсан дэглэмтэй, тогтвортой хөгжиж буй цөөн улсуудын нэг юм. Эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь өндөр, мөн уламжлалт аж ахуй эрхлэгч хөдөө орон нутгийн хүн ам ихтэй.

#### *БОНБУ-ний тогтолцоо ба оролцоо*

2011 онд батлагдсан БОНБУ-ний тухай хууль, 2012 онд батлагдсан БОНБУ-ний журмаар зохицуулдаг.<sup>15</sup> Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн зөвлөл нь үнэлгээ эрхлэгчдийг магадлан итгэмжлэх, чадавхийг бэхжүүлэх зорилготой мэргэжлийн холбоо байна.<sup>16</sup>

БОНБУ-ний үйл явцын ерөнхий дараалал доорх байдалтай байна. Үүнд:

Төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны газар (БОГ)-ын баталсан Төслийн тодорхойлолтын маягыг бөглөөд Байгаль орчны газрын орон нутгийн хэлтэст хүргүүлдэг.

БОГ нь тодорхойлолтод бичсэн мэдээллийг шалгаж үзээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд

1. БОННУ хийлгэх шаардлагагүй
2. Төслийн үйл ажиллагааг эхлэхээс өмнө Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /БОМТ/ батлуулах хэрэгтэй
3. БОННУ хийлгэх шаардлагатай
4. Стратегийн нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай

БОМТ батлуулах шийдвэр гарсан тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч дараах арга хэмжээг авах хэрэгтэй болно. Үүнд:

- Үнэлгээ хийх эрх бүхий мэргэжилтэн, байгууллагатай хамтран ажиллах
- Үнэлгээ эрхлэгч нь хуульд нийцүүлэн БОМТ-г боловсруулах /БОМТ-ний удирдамжийг баталсан, түүнд оролцооны асуудлыг тусгахаар заасан байдаг/
- Тайлангийн төслийг БОГ-т илгээж, дүгнэлт гаргуулах

Хэрэв БОННУ хийлгэх шаардлагатай бол дараах арга хэмжээг авах хэрэгтэй болно. Үүнд:

1. Үнэлгээ эрхлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулна.

<sup>15</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү. <https://www.gov.bw/environmental-management/application-environmental-assessment-ea-authorizations>

<sup>16</sup> Дэлгэрэнгүй мэдээллийн эндээс үзнэ үү. <https://beapa.org.bw/about-eapb/>

2. Үнэлгээ эрхлэгч нь төслийн зорилго, үйл ажиллагаа, үр ашиг, нөлөөллийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр 21 өдрөөс дээш хугацаанд зарлан мэдээлнэ.
3. 21 өдөр болсны дараа үнэлгээ эрхлэгч төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэд, олон нийттэй уулзалт зохион байгуулж хуульд заасан хүрээнд төслийн зорилго ба нөлөөллийн талаар танилцуулна.
4. Үнэлгээ эрхлэгч нь Урьдчилсан судалгааны тайлан ба Ажлын даалгаврын төслийг бэлтгэж БОГ-т хүргүүлнэ.

Урьдчилсан судалгааны удирдамжийг БОНБУ-ний журамд тусгасан бөгөөд оролцоог хангах үйл ажиллагааг нарийвчлан заасан. Үүнд: оролцогч талуудыг тодорхойлох алхмууд, оролцооны төлөвлөгөө боловсруулах, саналыг авах үйл ажиллагааг багтаасан байна. Ажлын даалгаврын загварыг журамд оруулсан бөгөөд үүнд оролцоог хангах шаардлагыг заавал оруулсан байхаар тусгажээ.

5. БОГ-аас Ажлын даалгаврыг баталсан хариу авсны дараа үнэлгээ эрхлэгч нь БОННУ хийж, үнэлгээний тайлангийн төслийг боловсруулж, БОГ-т хүргүүлнэ.

Тайлангийн бүтэц, агуулгын удирдамжийг журамд тодорхой заасан бөгөөд олон нийтийн оролцооны хэсгийг тодорхойлсон байна. Үүнд олон нийтээс санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын зорилго, арга, үр дүнг танилцуулахын зэрэгцээ оролцсон иргэд, байгууллагуудын мэдээлэл, хэлэлцүүлгийн тэмдэглэлийг хавсралтаар оруулахаар заажээ.

6. БОГ нь тайлангийн төслийг хуульд заасан шаардлагад нийцэж байна гэж үзвэл төсөл хэрэгжүүлэгчийн зардлаар өдөр тутмын эсвэл долоо хоног тутмын сонин болон төрийн мэдээллийн сэтгүүлд 4 долоо хоногийн турш долоо хоногт нэг удаа төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд, сонирхогч талуудын санал, шүүмжийг хүлээн авах тухай мэдээлэл хэвлүүлнэ. Үүнд дараах мэдээллийг тусгана: үйл ажиллагааны зорилго, цар хүрээ, байршил, таамаглаж буй байгаль орчны нөлөөлөл, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ.
7. БОГ шийдвэр гаргахдаа олон нийтээс ирүүлсэн санал, шүүмжийг харгалзан үзнэ.
8. Хэрэв шаардлагатай гэж үзвэл БОГ нийтийн сонсгол зохион байгуулж болно.
9. Төслийн тайлан хуульд заасан бүх шаардлагыг биелүүлсэн гэж үзвэл БОГ тайланг батална. Тайлан болон үнэлгээнд холбогдох мэдээлэл нь олон нийтэд нээлттэй байна.

СНУ хийх үе шат, шаардлага нь БОННУ-тэй ижил байна. БОНБУ-ний хуульд хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тодорхой заасан байна.

*Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

Ботсвана улсад үнэлгээний Ажлын даалгаврыг боловсруулах үеэс төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх /21-ээс дээш өдөр/, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар үнэлгээний цар хүрээ, анхаарах асуудалд иргэдийн саналаа тусгах боломж олгодог. Монгол улсад БОНБУ-ний тухай хуулиар төсөл хэрэгжүүлэгч Төлөв байдлын үнэлгээ хийхдээ орон нутгийн захиргааны санал авах, нөлөөллийн бүсийн иргэдтэй уулзаж мэдээлэл авах шаардлага байдаг боловч үнэлгээний талаар иргэдэд урьдчилсан мэдээлэл хэрхэн өгөх талаар нарийвчилсан зохицуулалт болон албан ёсны уулзалт, хэлэлцүүлэг хийх шаардлага байхгүй байна. Нэгэнт үнэлгээг эхлэхэд иргэдээс санал авч, ажлын удирдамжаа боловсруулсан учраас үнэлгээний дараагийн үе шатанд үл ойлголцол, зөрчилдөөн гарах нь багасч, заавал олон нийтийн сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулахгүйгээр бичгээр санал, шүүмж хүлээн авч тайланд тусгаж болдог байна.

Тухайн төсөл, ялангуяа уул уурхайн төслүүд орон нутгийн эсэргүүцэлтэй эхнээсээ тулгарах магадлалтай газарт үнэлгээний ажлын эхний үе шатнаас олон нийтийн саналыг авах, хэлэлцүүлэг хийх үйл ажиллагаа удаашрах эрсдэл үүсдэг байна.

## **Перу**

*БОНБУ-ний тогтолцоо*

1990-ээд оноос Өмнөд Америкийн олон улсууд БОНБУ-ний шаардлагыг холбогдох хуулиуддаа оруулж эхэлсэн. Перу улсын хувьд 1990 оноос БОНБУ-ний эрхзүйн зохицуулалтыг хэрэгжүүлэх болсон. Ингэхдээ БОНБУ-ний хэрэгжилтийг салбар яамдууд нь хариуцах байдлаар зохицуулсан. Иймээс 2015 оныг хүртэл салбарын яамдууд нь өөрсдийн салбарын байгаль орчны бодлого, журмыг батлан хэрэгжүүлж байсан байна. Үүнд өөрийн салбарын төсөл, хөтөлбөрийн БОНБУ-ний хэрэгжилтийг хариуцах чиг үүрэг багтаж байсан байна.

2008 онд Байгаль орчны яамыг байгуулж байгаль орчны бодлогын нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэх болсон байна. Улмаар 2009 онд БОНБУ-ний эрх зүйн зохицуулалтыг шинэчилжээ. Энэ шинэчлэлтээр БОНБУ-ний нэгдмэл удирдлагын тогтолцоонд аажмаар шилжих эхлэл тавигдсан бөгөөд 2012 онд Тогтвортой хөрөнгө оруулалтыг дэмжих байгаль орчны зөвшөөрлийн үндэсний төв (SENACE) гэдэг БОНБУ-ний хэрэгжилтийг хариуцсан агентлагийг байгуулсан.

Улмаар 2015 оноос эхлэн салбар яамдын БОНБҮ-тэй холбоотой чиг үүргийг үе шаттайгаар төвлөрүүлэх бодлого хэрэгжиж байна.<sup>17</sup>

Перу улсын хувьд 2000-аад оны үеээс уул уурхайн төслүүдийг тойрсон маргаан, зөрчилдөөн маш ихэссэн. Эдгээрийн нэг томоохон шалтгаан нь БОНБҮ-нд итгэх олон нийтийн, орон нутгийн иргэдийн итгэл алдарсан явдал гэж үздэг. Салбарын яамдууд нь төслийн БОНБҮ-ний хэрэгжилтийн хангахад эдийн засгийн үр ашиг ба байгаль орчны хамгааллыг тэнцвэрийг хадгалах боломжгүй байснаас үүдэн БОНБҮ-тэй холбоотой гомдол, маргаан ихэссэн байна. Тиймээс сүүлийн жилүүдэд өрнөж буй БОНБҮ-ний тогтолцоог сайжруулах ажлууд нь хөрөнгө оруулалтын орчинг дэмжих, олон нийтийн итгэлийг сэргээх зорилготой байна. Жишээ нь SENACE бөгөөд энэ нь БОНБҮ-ний үйл явцыг чанартай, хурдан шуурхай хэрэгжүүлэх төрийн үйлчилгээг үзүүлэх чиг үүрэгтэй бие даасан агентлаг юм.<sup>18</sup>

Хуульд байгаль орчны зөвшөөрөл шаардлагатай төслүүдийг байгаль орчны эрсдлийн түвшингээр нь 3 бүлэгт ангилсан. Эдгээрээс гадна бодлого, хөтөлбөрийн тухайд Стратегийн нөлөөллийн үнэлгээ /СНҮ/ хийх зохицуулалттай байна.<sup>19</sup>

#### Бүдүүвч 4. Перу улсын БОНБҮ-ний ангилал

Байгаль орчны нөлөөллийн мэдүүлэг	• Байгаль орчны сөрөг нөлөөлөл маш багатай төслүүд
Байгаль орчны нөлөөллийн хагас нарийвчилсан үнэлгээ	• байгаль орчны тодорхой хэмжээний сөрөг нөлөөлөлтэй боловч энгийн арга замаар тэдгээрийг бууруулах, арилгах боломжтой төслүүд
БОННУ	• Байршил, хэмжээ, бусад онцлог шинж чанарын улмаас байгаль орчны их хэмжээний сөрөг нөлөөлөл үзүүлэх боломжтой төслүүд
Стратегийн нөлөөллийн үнэлгээ	• Бодлого, хөтөлбөрүүд

<sup>17</sup> Mariano Castroa, Ernesto Sánchez-Trianab, Fernando Loayzac, Juan Albarracin-Jordand, and Ana Luisa Lima. EIA reform in Peru. 2014.

<https://citeseerx.ist.psu.edu/viewdoc/download?doi=10.1.1.568.841&rep=rep1&type=pdf>

<sup>18</sup> OECD Environmental Performance Reviews: Peru 2017. <https://www.oecd-ilibrary.org/sites/9789264283138-6-en/index.html?itemId=/content/component/9789264283138-6-en>

<sup>19</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү. <https://www.minam.gob.pe/legislaciones/sistema-nacional-de-evaluacion-de-impacto-ambiental/>

Үнэлгээний төслийн ангиллыг тогтоохдоо дараах шалгууруудыг баримтална.<sup>20</sup>  
Үүнд:

- Хүн амын эрүүл мэндийг хамгаалах
- Агаар, ус, хөрсний болзошгүй бохирдол, дуу чимээ, хатуу, шингэн хог хаягдал, хий, цацраг идэвхт бодисын хэмжээ
- Байгалийн нөөц, ялангуяа ус, хөрс, ургамал, амьтны аймгийг хамгаалах
- Дархан цаазтай газрыг хамгаалах
- Чухал экосистем ба байгалийн үзэсгэлэнт газрууд
- Биологийн олон янз байдал ба түүний бүрэлдэхүүн хэсгүүдийг хамгаалах
- Орон нутгийн амьдрах орчин, амьжиргаа
- Хотын нийтийн зай талбайг хамгаалах
- Археологи, барилга, түүх соёлын өвийг хамгаалах

БОНБУ хийх үндсэн үе шатууд нь төслийн үнэлгээ хийлгэх өргөдөл гаргах, аль ангиллын үнэлгээнд хамаарахыг тогтоох, үнэлгээ хийх, үнэлгээг дүгнэх, хяналт, мониторингоос бүрдэнэ.

#### *Олон нийтийн оролцооны зохицуулалт*

Перу улсын 2005 оны Байгаль орчны ерөнхий хуульд БОНБУ-ний зорилго, чиг үүргийг тодорхойлсон байна. Түүнчлэн уг хуульд иргэний оролцооны талаарх төрийн байгууллагуудын үүргийг тодорхойлсон байна /50-р зүйл/. Үүнд:

- Иргэдийн мэдээлэл авах эрхийг хурдан шуурхай хэрэгжүүлэх
- Иргэний оролцооны талаарх сургалт, зөвлөлгөөг хэрэгжүүлэх
- Иргэний оролцооны механизмуудыг бүрдүүлэх
- Иргэний оролцоог хязгаарлаж буй зохицуулалт, шаардлагуудыг цуцлах

Уг хуулийн 51-р зүйлд иргэдийн оролцоог хангах шалгуур үзүүлэлтүүдийг тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн эрх бүхий байгууллага нь холбогдох мэдээллийг олон нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр хүргэх, эрх ашиг нь хөндөгдөж буй хэсэгт хүртээмжтэй арга замаар мэдээлэх
- Техникийн, мэргэжлийн судалгаа, үнэлгээний тайланг батлахдаа энгийн иргэд, сонирхогч талуудад ойлгогдохуйц хялбаршуулсан хувилбарыг танилцуулдаг байх
- Хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжих орон нутагт наад зах нь нэг удаа олон нийтийн сонсгол зохион байгуулж нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн оролцоог хангах, ингэхдээ албан ёсоор баримтжуулж, тайлагнах
- Олон нийтийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын тайланг ил тод мэдээлэх

2009 онд шинэчлэн батлагдсан БОНБУ-ний тухай хуульд олон нийтийн оролцоог хангах нарийвчилсан зохицуулалтууд орсон.

---

<sup>20</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.  
[https://cdn.www.gob.pe/uploads/document/file/12770/Ley-N\\_-27446.pdf](https://cdn.www.gob.pe/uploads/document/file/12770/Ley-N_-27446.pdf)

Хуулийн иргэний оролцоо гэсэн хэсэгт /13-р зүйл/ оролцооны 2 хэлбэрийг тодорхойлсон байна. Үүнд:

- Эрх бүхий байгууллагаас төслийн үнэлгээтэй холбоотой өргөдөл, үнэлгээний тайланг хянан дүгнэх үед албан ёсоор мэдээлэл түгээх, иргэдийн оролцоон хангах
- Төсөл хэрэгжүүлэгчийн иргэдийн оролцоог хангахад чиглэсэн арга хэмжээ

Улмаар уг хуульд иргэдийн оролцоог хангах шаардлагыг дараах байдлаар тодорхойлсон /14-р зүйл/. Үүнд:

А) Төслийн ангиллыг тогтоох үе шатанд эрх бүхий байгууллага төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдийн төлөөлөл холбогдох хүмүүсээс тодруулга, санал авах

Б) Төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээний баг нь Иргэдийн оролцооны төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх

В) БОННУ болон хагас БОННУ хийх үед эрх бүхий байгууллага албан ёсны санал авах хэлэлцүүлэг зохион байгуулах, холбогдох зар мэдээг хүргэх, хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд ил тод мэдээлэх, ингэхдээ зардлыг төсөл хэрэгжүүлэгч хариуцах

2009 онд БОННУ-ний хуулийн хэрэгжилтийн хангах журмыг баталсан бөгөөд уг журамд иргэний оролцоог хангах арга замуудыг танилцуулсан байна.

Уг журамд иргэний оролцооны үйл явц нь төслийг батлах, цуцлах утга санааг агуулахгүй болохыг дурьдсан байна.

БОННУ хуульд зааснаар БОННУ-ний тайлан нь дараах агуулгатай байна /10-р зүйл/. Үүнд:

- а) Төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт, түүний нөлөөллийн талбайн үндэс суурь;
- б) Төслийн бүх үе шатанд болон бүх хугацаанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл
- в) Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- г) Иргэний оролцооны төлөвлөгөө
- д) Хяналт, мониторингийн төлөвлөгөө
- е) Байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн эдийн засгийн үнэлгээ
- ё) Тайлангийн энгийн ойлгомжтой хураангуй
- ж) Эрх бүхий байгууллагаас тогтоосон бусад шаардлага

БОННУ-ний тайланг эрх бүхий байгууллага хянан үзээд дүгнэлт тайлан боловсруулж, уг тайланд үндэслэн тогтоол гаргана. Уг дүгнэлт тайлан олон нийтэд нээлттэй байна. СНҮ-ний тухайд БОЯ-наас Байгаль орчны тайлан боловсруулж холбогдох бодлого, хөтөлбөр хэрэгжүүлэгчид хүргүүлдэг.

*Олон нийтийн сонсгол зохион байгуулах журам*

2009 онд Байгаль орчны мэдээллийн ил тод байдал, иргэний оролцоог хангах талаар Засгийн газрын тогтоол батлагдсан. Уг тогтоолд иргэний оролцоог хангах дараах механизмууд байна гэж заасан байна /29-р зүйл/. Үүнд:



- а) Сонсгол
- б) Олон нийтийн оролцоотой семинарууд
- в) Санал асуулга
- г) Санал авах хайрцаг
- д) Бүс нутгийн болон орон нутгийн байгаль орчны зөвлөл
- е) Ажлын хэсэг
- ё) Хамтарсан хороо

Уг тогтоолд сонсгол зохион байгуулах арга зүйг мөн тодорхойлсон /30-р зүйл/.

Төсөл хэрэгжүүлэгч төсөл хэрэгжих орон нутгийн иргэдийн дунд сонсгол зохион байгуулах бөгөөд энэ нь мэдээлэл хүлээн авах зорилготой бөгөөд ямар нэгэн шийдвэр гаргах үүрэггүй байна.

Сонсгол зохион байгуулахад байгаль орчны ба орон нутгийн холбогдох байгуулага хяналт тавьж оролцоно.

Төсөл хэрэгжүүлэгчийн Иргэний оролцооны төлөвлөгөө нь дараах агуулгатай байна. Үүнд:

- Төслийн оролцогч талуудыг тодорхойлох
- Хэлэлцүүлэг хийх, санал авах зорилго тодорхойлох
- Зөвлөлдөх үйл явцын хүрээг тодорхойлох
- Хэрэгжүүлэх хуваарь
- Хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн
- Санал мэдээлэл хүлээн авах арга зам
- Мэдээлэл түгээх арга замууд
- Ирсэн саналуудын бүртгэл, үр дүн

БОННУ-ний сонсголын зар мэдээг албан ёсны цахим хуудас болон хэвлэл мэдээлийн хамгийн өндөр хүртээмжтэй сувгаар хүргэнэ. СНУ-ний тухайд үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн сувгаар зар мэдээ хүргэнэ.

Нийтийн зар мэдээнд төслийн товч танилцуулга, ямар асуудлаар санал авч буйг тодорхой бичсэн тайлбар, төслийн байршил, санал хүлээн авах суваг ба хугацаа, хэлэлцүүлгийн огноо, саналд хариу өгөх хугацаа ба арга, оролцооны үйл явцад холбогдох хууль эрх зүйн зохицуулалтыг багтаах ёстой.

Уг тогтоолд сонсгол хэрхэн зохион байгуулах талаар дэлгэрэнгүй шаардлагууд орсон /33-р зүйл/.

- Сонсгол нь иргэний бичиг баримт бүхий Перу улсын иргэн бүрд нээлттэй.
- БОННУ хийх үе төсөл хэрэгжүүлэх орон нутагт доод тал нь нэг удаа сонсгол зохион байгуулна. Зохион байгуулах газрыг орон нутгийн удирдлага шийдвэрлэнэ.

- Төслийн тайланг хүлээн авсанаас хойш 30 хоногийн дотор сонсгол зохион байгуулах талаар холбогдох эрх бүхий байгууллага зарлана. Зохион байгуулах өдрөөс 7 хоногийн өмнө 2 дахь удаа зарлана.
- Зар мэдээг орон нутгийн удирдлагын ордны зарлалын самбар, үндэсний эсхүл орон нутгийн томоохон сонинд нийтэлнэ.
- Иргэд тайлангийн төсөл ба хураангуй мэдээлэлтэй танилцах боломжтой байна.
- Сонсгол дууссанаас хойш 30 хоногийн хугацаанд санал илгээх боломжтой байна. Сонсгол зохион байгуулсан талаарх мэдээллийг холбогдох эрх бүхий байгууллага нийтэд мэдээлнэ.
- Сонсгол дээр төсөл хэрэгжүүлэгчээс хийх танилцуулгын агуулгын хүрээг тодорхойлсон.
- Сонсголд үнэлгээ хийсэн багийн ахлагч оролцох ёстой.
- Танилцуулга хийсний дараа асуулт хариулт явагдана. Хэлэлцүүлгийг нэг удаа болон хэд хэдэн удаагийн хуралдаанаар хийж болно.
- Хуралдааны тэмдэглэл, холбогдох баримт сэлтийг тайланд хавсаргана. Тэмдэглэлд хэлэлцүүлэгт оролцсон талуудын төлөөлөл гарын үсэг зурж, оролцогчдын жагсаалтыг хавсаргана.

#### *Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

Перу улсын хувьд БОНБҮ-тэй холбоотой үл ойлголцол, маргаанаас сэргийлэх, БОНБҮ-нд итгэх олон нийт, орон нутгийн иргэдийг сэргээх, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинг дэмжих зорилгоор тогтолцооны шинэчлэл хийсэн байна. Ингэхдээ БОНБҮ-ний хуулийн хэрэгжилтийг хариуцсан бие даасан агентлаг байгуулж, БОНБҮ-ний талаарх олон нийтэд зориулсан мэдээлэл сурталчилгааг ажлыг өрнүүлсэн байна.

Перу улсын хувьд уул уурхайн томоохон төслүүд болон байгаль орчны эрсдэл өндөртэй бусад төслүүдийн үнэлгээнд илүү ач холбогдол өгч үнэлгээний ангилал, түүнээс хамаарсан оролцооны зохицуулалт хийсэн байна. Төслийн ангилалд тавигдах шалгуурт хүн амын эрүүл мэндэд үзүүлэх болзошгүй нөлөөллийг анхаарч авч буйг онцлон дурьдууштай юм.

Төрийн эрх бүхий байгууллага нь холбогдох мэдээллийг эрх ашиг нь хөндөгдөж буй хэсэгт хүртээмжтэй арга замаар мэдээлэх, техникийн, мэргэжлийн судалгаа, үнэлгээний тайланг батлахдаа энгийн иргэд, сонирхогч талуудад ойлгогдохуйц хялбаршуулсан хувилбарыг танилцуулдаг байх, олон нийтийн санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын тайланг ил тод мэдээлэх шаардлагыг хэрэгжүүлж байна.

Орон нутгийн эрх бүхий байгууллага нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран төсөл хэрэгжих орон нутагт олон нийтийн сонсгол зохион байгуулах ба сонсгол нь шийдвэр гаргах биш иргэдийн санал авах зорилготой гэдгийг журамд тодорхой тусгасан байна. Сонсголын өмнө иргэдэд мэдээлэлтэй танилцахад шаардлагатай хугацаа өгч, сонсгол дууссаны дараа ч саналаа хүргүүлэх боломжтой байхаар зохицуулсан нь чухал давуу тал юм. Иргэд, олон нийтээс

санал авах, хэлэлцүүлэг хийх ажлын үр дүн нь Иргэний оролцооны төлөвлөгөө буюу тайлан хэлбэрээр нэг бүрдэл хэсэг болдог санал авах үйл явц, түүний үр дүнг хянах чухал арга зам болж байна.

## Уул уурхай түшиглэсэн эдийн засгийн өндөр хөгжилтэй улсын туршлага

### Австрали, Күинсланд муж

#### БОНБУ-ний тогтолцоо

Дэлхий дахинаа БОНБУ-г анхлан нэвтрүүлсэн улсуудын нэг нь Австрали юм. 1974 онд Холбооны улсын байгаль орчныг хамгаалах тухай хуульд анх БОНБУ-ний зохицуулалтыг тусгажээ. Энэ хуулийг 1999 онд Байгаль, биологийн олон төрөл зүйлийг хамгаалах тухай болгон өөрчилсөн бөгөөд холбооны улс даяар мөрдөх БОНБУ-ний суурь зарчмуудыг агуулдаг.<sup>21</sup>

Австрали улс нь холбооны улс бөгөөд нийт 6 муж, 2 нутаг дэвсгэрээс бүрдэнэ. Эдгээр нь өөрсдийн бие даасан хууль, эрх зүйн орчны хүрээнд БОНБУ-ний эрх зүйн зохицуулалт, холбогдох институцуудтай. Холбооны улсын хэмжээнд мөрдөгдөх БОНБУ-ний хуулийн зохицуулалт, муж улсын түвшинд хэрэгжих хуулийн зохицуулалт тус бүр үйлчилдэг учраас тэдгээрийн уялдааг хангах хоёр талт гэрээгээр давхардал, зөрүүг зохицуулдаг. Зарчмын хувьд муж, нутаг дэвсгэрийн БОНБУ-ний зохицуулалтыг холбооны засгийн газар хүлээн зөвшөөрч, тэдгээрээс гаргасан дүгнэлтийг шийдвэр гаргахдаа үндэслэл болгодог.

Мужуудын хооронд БОНБУ-ний үйл явц ерөнхийдөө ижил зарчим, үе шаттай байдаг боловч хуулийн нэр томъёо, үнэлгээний цар хүрээ, хугацаа гэх мэт процессын ялгаа их байдаг. Бид уул уурхайн гол бүс нутгуудын нэг, мөн хөдөө аж ахуй, аялал жуулчлалын хөгжлөөр тэргүүлэгч Күинсланд мужийн БОНБУ-ний зохицуулалтын талаар авч үзэв. Бусад мужуудтай харьцуулахад Күинсланд мужийн хувьд БОНБУ-ний тогтолцооны боловсронгуй байдал, цар хүрээ, оролцооны журмын хувьд нэлээд давуу талтай байсан.

Күинсланд муж нь БОНБУ-ний шаардлагыг анх нэвтрүүлсэн мужуудын нэг юм. Анх олон тооны хууль, журмын дагуу БОНБУ-г зохицуулж байсан. Өнөөгийн байдлаар 3 тусдаа хуулийн хүрээнд БОНБУ-г зохицуулж байна. 2009 онд батлагдсан Тогтвортой төлөвлөлтийн хуулиар уул уурхай, газрын тосны үйл ажиллагаанаас бусад төслүүдийн БОНБУ-ний хэрэгжилтийг зохицуулдаг. 1994 оны Байгаль орчныг хамгаалах хуулиар уул уурхай, газрын тосны төслүүдийг, 1971 оны Мужийн хөгжил, нийтийн ажлын тухай хуулиар “томоохон төслүүд”-ийн БОНБУ-г зохицуулж байна.

Күинсланд мужийн Байгаль орчин, шинжлэх ухааны газар нь байгалийн нөөц ашиглалттай холбоотой зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Үүнд уул уурхай, газрын тос, нүүрсний хий, газрын дулаан, хүлэмжийн хийн агуулах хамаарна. Байгаль орчинд их хэмжээний нөлөөлөл үзүүлэх байгалийн нөөц ашиглах төслийг хэрэгжүүлэхэд Байгаль орчинд нөлөөлөх байдлын дүгнэлт буюу үнэлгээ хийлгэх шаардлага тавьж болно.

---

<sup>21</sup> Дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү.  
<https://www.qld.gov.au/environment/pollution/management/eis-process>

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд БОНБУ-ний зорилгыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Төслийн байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллийг бууруулах ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт мониторинг хийх арга замуудыг үнэлэх
- Төслийг хэрэгжүүлэх боломжит хувилбаруудыг судлах
- Олон нийтэд төслийн тухай мэдээлэл өгөх
- Эрх бүхий байгууллагаас байгаль орчны зөвшөөрөл олгох үндэслэл болох
- Бусад муж, холбооны улсын эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх

БОНБУ хийх шаардлагатай төслүүд нь байгаль орчны эрсдэл өндөр байхын зэрэгцээ мужийн эдийн засагт чухал ач холбогдолтой төслүүд байх нь элбэг.

Тухайн төсөл БОНБУ хийлгэх шаардлагатай эсэхийг хянахдаа дараах шалгуурыг баримталдаг. Үүнд:

- Хуульд заасан харгалзан үзэх бодлого, эрхзүйн үзүүлэлтүүд
- Байгалийн нөөц ашиглалтын тодорхой босго хэмжээ заасан үзүүлэлтүүд
- Нөлөөллийн цар хүрээ, эрсдэл (жишээ нь мужийн байгаль орчны чухал ач холбогдолтой асуудал, усны чанар, байгаль орчны эмзэг бүс нутаг, агаар, дуу чимээ)
- Олон нийтийн эрх ашиг
- Нөлөөллийн талаарх тодорхой бус байдал
- Үндэсний хэмжээний ач холбогдол бүхий асуудал
- Нийгэм, эдийн засгийн нөлөөлөл
- Хуримтлагдах нөлөөлөл

Байгаль орчны хуулийн дагуу Байгаль орчинд нөлөөлөх байдлын тодорхойлолт /БОНБТ/ буюу БОННУ хийх тохиолдолд дараах ерөнхий 3 үе шатны дагуу явагдана. Үүнд:

- Ажлын даалгавар боловсруулах, хэвлэн нийтлэх
- БОННУ-ний тайлангийн төсөл боловсруулах, олон нийтэд мэдээлэх
- БОННУ-ний тайлангийн эцсийн хувилбарыг боловсруулж, батлах

Хүснэгт 3. Күинсланд мужийн БОНБУ-ний үе шатууд ба олон нийтийн оролцоо

Ажлын боловсруулах, нийтлэх	даалгавар хэвлэн	БОННУ-ний төслийг олон боловсруулах, нийтэд мэдээлэх	БОННУ-ний тайланг боловсруулж, батлах
Төсөл хэрэгжүүлэгч даалгаврын төслийг Байгаль орчны газарт /БОГ/- т хүргүүлнэ.	Ажлын төслийг	Төсөл хэрэгжүүлэгч БОННУ-ний төслийг хүргүүлнэ /2 жилийн дотор/.	БОГ БОННУ-ний тайланг судлан үзсэн үнэлгээний тайланг бэлтгэж төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлж, хэвлэнэ нийтэлнэ /20-30 өдөр/.
БОГ нь Ажлын даалгаврын зар мэдээг боловсруулж, хэвлэн нийтэлнэ /15 өдөр, 5 өдөр/. Төсөл хэрэгжүүлэгч төслийн нөлөөлөлд өртөж		БОГ БОННУ-ний судлан үзээд хэрэгжүүлж болох эсэхийг шийдвэрлэнэ /Алхам 20 өдөр/.	

болзошгүй болон сонирхогч иргэдэд зар мэдээг түгээнэ. Ажлын даалгаврын төсөлд санал авах хугацаа /доод тал нь 30 өдөр/.	Төсөл хэрэгжүүлэгч БОННУ-ний зар мэдээг боловсруулж, хэвлэн нийтэлж, нөлөөлөлд өртөгч, сонирхогч иргэдэд хүргэнэ /20 өдөр/. БОННУ-ний санал авах хугацаа /30 өдөр/	
Төсөл хэрэгжүүлэгч Ажлын даалгаврын төсөлд өгсөн санал, шүүмжид хариу өгсөн тайлбараа БОГ-т хүргүүлнэ /10 өдөр/. Ажлын даалгаврыг БОГ эцэслэн баталж, хэвлэнэ нийтэлнэ /20 өдөр/.	Төсөл хэрэгжүүлэгч зар мэдээг үнэн зөв хүргэсэн гэдэг тодорхойлолт гаргана.  БОГ ирсэн саналуудыг төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ /10 өдөр/.  БОННУ-ний талаар санал, шүүмжид төсөл хэрэгжүүлэгч хариу өгсөн тайлбар, нэмэлт өөрчлөлтөө БОГ-т хүргүүлнэ /10 өдөр/.  БОГ нэмэлт өөрчлөлт оруулсан БОННУ-ний тайланг судлан дүгнэлт гаргана /10 өдөр/.	

### *Олон нийтийн оролцооны зохицуулалт*

Ажлын даалгаврын төслийг төсөл хэрэгжүүлэгч бэлтгэн хүргүүлснийг БОГ хянан үзээд хэрэв боломжтой гэж үзвэр зар мэдээ бэлтгэж, зар мэдээг төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ. Үүний дараа БОГ батлагдсан маягтын дагуу бэлтгэсэн зар мэдээг үндэсний хэмжээний эсвэл мужийн хэмжээний сонинд нийтлүүлдэг.

Ажлын даалгаврын тухайд санал авах хугацаа доод тал нь 30 өдөр байна. Энэ хугацаанд БОГ нь төрийн холбогдох яам, газрууд, орон нутгийн төрийн байгууллагууд, эрдэм шинжилгээний хүрээлэн, судлаачид, хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, иргэний нийгмийн холбогдох байгууллагуудаас санал, зөвлөмж авч болно. БОГ нь бичгээр ирүүлсэн, тодорхой нэр хаягтай, гарын үсэг зурсан, хуульд заасан хугацаанд ирүүлсэн саналуудыг хүлээн авна.

БОГ нь Ажлын даалгаврын тухай талуудаас хүлээн авсан бүх саналуудыг төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь 20 өдрийн дотор саналуудын тойм, саналуудад өгөх тайлбар, нэмэлт өөрчлөлт оруулсан Ажлын даалгаврын төслийг БОГ-т хүргүүлнэ. Энэ хугацааг харилцан зөвшилцөөд сунгаж болно. Эдгээрийг харгалзан үзсэний үндсэн дээр БОГ Ажлын даалгаврыг эцэслэн баталж өөрийн цахим хуудаснаа бүрэн эхээр нь байршуулна.

Ажлын даалгаварт төсөл хэрэгжүүлэгч оролцогч талууд болон олон нийттэй зөвлөлдөх төлөвлөгөөг боловсруулахаар тусгадаг. Зөвлөлдөх үйл явцын цар хүрээ нь төслийн талаарх олон нийтийн сонирхол, байгаль орчин, эдийн засаг,

нийгмийн ач холбогдлоос хамаарна. Зөвлөлдөх үйл явцыг аль болох эрт эхэлж, тууштай хэрэгжүүлэх нь зүйтэй гэж онцолсон байна.

Зөвлөлдөх төлөвлөгөөний агуулга

- Зөвлөлдөх үйл явцын зорилго
- Зөвлөлдөх үйл явцын хуваарь, хугацаа
- Оролцох хүмүүсийн тоо
- Зөвлөлдөх арга хэлбэр
- Зөвлөлдсөн хүмүүст хариу өгөх арга, хэлбэр
- Зорилгодоо хүрсэн эсэхийн үнэлгээ
- Санал гарсан асуудлын дүн шинжилгээ
- Асуудлыг БОННУ-нд хэрхэн авч үзэх тайлбар
- Саналуудын үр дүнд оруулах нэмэлт өөрчлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нь төслийн Нийгмийн нөлөөллийн үнэлгээг холбогдох хуульд нийцүүлэн боловсруулна. ННУ нь төслийн нийгэмд үзүүлэх эерэг, сөрөг нөлөөллийг, хариу арга хэмжээг тодорхойлох ёстой. ННУ нь БОННУ-ний тайлангийн нэг бүрэлдэхүүн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ-ний тайлангийн төслийг боловсруулж дууссаны дараа зар мэдээг хуульд заасан шаардлага, маягтын дагуу боловсруулна. Төсөл хэрэгжүүлэгч нь зар мэдээг нөлөөлөлд өртөгч талууд, бусад холбогдох талуудад хүргүүлэх, БОГ-т хүргүүлж цахим хуудсанд нь байршуулах, сонинд хэвлүүлэх, БОННУ-ний тайлангийн хувийг өөрийн цахим хуудаснаа байршуулах ажлыг хариуцна.

Цахим болон хэвлэмэл хувилбарыг санал авах хугацаа эхлэхээс өмнө холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэх ёстой. Зар мэдээг хэвлүүлснээс хойш 10 хоногийн дотор төсөл хэрэгжүүлэгч нь БОГ-т хуульд нийцүүлэн зар мэдээг түгээсэн тухай тайлбар, зар мэдээг хүргүүлсэн хүмүүсийн нэр, хаяг, зар мэдээний нэг хувийг өгнө.

БОННУ-ний тайлангийн төсөлд санал авах хугацаа 30 өдөр байна.

Саналаа цахим хуудсаар, мэйлээр, шуудангаар илгээж болно. Санал илгээхдээ дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Гол асуудлыг товч тодорхой илэрхийлэх
- Тайлангийн хуудасны дугаар заах
- Яагаад таны санал чухал болох, харгалзан үзэх ёстойг тайлбарлах
- Төслийн талаарх ерөнхий саналаас зайлсхийх

БОГ хүлээн авсан саналуудыг 10 өдөрт багтаан төсөл хэрэгжүүлэгчид илгээнэ. Төсөл хэрэгжүүлэгч 20 өдөрт багтаан саналын тойм, хариу тайлбар, нэмэлт өөрчлөлтийн тайланг БОГ-т илгээнэ. БОГ 20 өдөрт багтаан дээрх тайланг хянан үзээд БОННУ-ний дараагийн шатанд шилжүүлэх эсэхийг шийднэ. Хэрэв татгалзсан шийдвэр гаргавал төсөл хэрэгжүүлэгч БОЯ-ны сайдад өргөдөл гарган дахин хянуулж, түүний үндсэн дээр засвар, өөрчлөлт оруулж болно.

БОГ төсөл хэрэгжүүлэгчийг тайлбар, нэмэлт өөрчлөлт хангалттай гэж үзсэн бол 30 өдрийн дотор БОННУ-ний тайланд үнэлгээг хийсэн тайланг хүргүүлнэ.

Батлагдсан БОННУ-ний тайланг 12 сарын хугацаанд олон нийт цахимаар үзэх боломжтой байх ёстой.

БОНБУ-ний мэдээллийн портал нь тухайн төслийн үнэлгээнд холбогдох мэдээллийг тогтмол шинэчилж, иргэд, олон нийт шаардлага мэдээллийг тухай бүрд авах боломжоор хангадаг.

БОНБУ-ний портал нэгж үнэлгээнд холбогдох мэдээллийг оруулсан байдал

- Төслийн нэр
- Үнэлгээний одоогийн үе шат
- Төслийн техникийн биш, товч тодорхойлолт: зорилго, гол хийгдэх ажлууд гэх мэт
- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр
- Байршил: ойролцоох сууринаас хэдэн км гэх мэт энгийн ойлгомжтой байдлаар
- Холбогдох орон нутгийн захиргаа
- Төслийн хэрэгжих хугацаа
- Ажлын байрны тоо
- Холбооны Засгийн газрын зөвшөөрөл хэрэгтэй эсэх
- БОННУ-ний аль үе шатанд байгааг тэмдэглэх
- Холбогдох мэдээллүүд бүрэн эхээрээ: анхны олон нийтийн зар мэдээ, Ажлын даалгаврын төсөл, зар мэдээ, Ажлын даалгавар, Үнэлгээний тайлангийн төсөл, олон нийтийн саналд өгсөн хариултууд, БОННУ-ний тайлан
- Нэмэлт мэдээлэл авч болох байгууллага ба хүний мэйл болон утас

#### *Монгол улсад ач холбогдолтой туршлага, сургамж*

Юуны өмнө Күинсланд муж болон Австралийн бусад муж, нутаг дэвсгэрт томоохон эсвэл хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд маш их сөрөг нөлөөтэй байж болзошгүй харьцангуй цөөн төслүүдэд БОНБУ хийдэг гэдгийг дурдах нь зүйтэй. Төслийн үнэлгээнд тавигдах шаардлага нарийвчлал өндөртэй, үнэлгээг гүйцэтгэх хугацаа харьцангуй урт байдаг. Ажлын даалгаврын хүчинтэй хугацаа буюу нарийвчилсан үнэлгээг хийж дуусгах хугацаа 2 жил байдаг. Тийм учраас үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тус мужийн зохицуулалтыг Монгол улсын хууль, эрхзүйн зохицуулалттай шууд харьцуулахад бэрхшээлтэй юм. Харин Монгол улсын онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж болох хэд хэдэн чухал туршлагууд байна. Үүнд:

- Ажлын даалгаварт төсөл хэрэгжүүлэгч нь Зөвлөлдөх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхээр тусгадаг үнэлгээний эхнээс оролцоог хангахад давуу талтай байна. Энэ төлөвлөгөөний хэрэгжилт нь үнэлгээний тайланд нэг бүлэг болон ордог.
- Зар мэдээ нийтлэх, үнэлгээний мэдээллийг цаг тухайд нь ил тод байршуулах нарийвчилсан зохицуулалт иргэдийн мэдээлэл авах эрхийг хангах, бусад оролцогч талууд оролцох, хяналт тавих боломжийг нэмэгдүүлж байна.
- Иргэдийн санал, шүүмжийг хэрхэн авч үзсэн, тайланд тусгасан эсэх, түүний үндэслэлийг төсөл хэрэгжүүлэгч эргэн тайлагнадаг.
- Үнэлгээний тайлан нь 200-300 болон түүнээс олон хуудас байдаг. Үнэлгээний тайлангийн мэдээллийг иргэдэд ойлгомжтой, техникийн биш хэллэгээр товч танилцуулахад анхаарч байна.



## Монгол улс ба олон улсын туршлагын харьцуулалт

### 1. БОННУ-нд олон нийтийн оролцоог хангах хуулийн шаардлага

Гадаад улсуудын БОНБҮ-ний хууль, журмуудад заасан зохицуулалтыг харьцуулахад Монгол улсын холбогдох хуулиудад нарийвчилсан үнэлгээний үе шатанд оролцоог хангах заалт тодорхой хэмжээнд орсон байна. Монгол улсад Ажлын даалгавар буюу Ерөнхий үнэлгээний дүгнэлт гарахад олон нийтээс албан ёсоор санал авах талаар хууль, журмаар зохицуулаагүй бол нарийвчилсан үнэлгээний явцад болон үнэлгээний тайлангийн төслийг боловсруулж дууссаны дараа албан ёсоор санал авах ёстой. ОХУ, Казакстан, Ботсвана улсын хуульд төсөл хэрэгжүүлэгч Ажлын даалгаврын төсөлд олон нийт, төслийн орон нутгийн иргэдийн саналыг авах ажлыг хариуцдаг. ОХУ, Казакстан улсын хувьд зар мэдээ нийтэлж, бичгээр болон цахимаар санал хүлээн авдаг бол Ботсванад төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй орон нутгийн иргэдтэй уулзалт хийх замаар санал авдаг байна. Харин Австралийн Квинсланд мужид Байгаль орчны газар олон нийтийн саналыг бичгээр болон цахимаар хүлээн авч төсөл хэрэгжүүлэгчид хүргүүлдэг байна.

### Хүснэгт 4. Оролцоог хангах хуулийн шаардлага

	Монгол	БНХАУ	ОХУ	БНСУ	Казакстан	Ботсвана	Перу	Австрали /Квинсланд/
Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахад албан ёсоор санал авах ёстой юу?	Үгүй	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Үгүй	Тийм
Нарийвчилсан үнэлгээ хийх явцад санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах ёстой юу?	Тийм	Тийм	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм
Нарийвчилсан үнэлгээний ажлын тайлангийн төслийг хэлэлцүүлж санал авах ёстой юу?	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм

### 2. Нарийвчилсан үнэлгээ хийх явцад албан ёсоор санал авах зохицуулалт

Монгол улсын хувьд нарийвчилсан үнэлгээг хийх явцад санал авах, хэлэлцүүлэг зохион байгуулах шаардлага тавьдаг боловч хууль, журамд олон нийтэд ямар мэдээлэл хэн, хэзээ өгөх, иргэд, оролцогч талууд саналаа хэрхэн гаргах үйл ажиллагааг нарийвчлан зохицуулаагүй байна. Нарийвчилсан үнэлгээг эхлэх үеэс олон нийтэд нээлттэй мэдээлэл танилцуулах, санал авах талаар БНХАУ, Перу, Австрали улсууд нэлээд нарийвчилсан зохицуулалттай байна. Түүнчлэн эдгээр улсуудад оролцооны эсвэл зөвлөлдөх үйл ажиллагааны тайланг янз бүрийн хэлбэрээр боловсруулж, үнэлгээний тайланд оруулах, хавсаргах байдлаар оролцооны явц, үр дүнг баримтжуулж байна.

## Хүснэгт 5. Нарийвчилсан үнэлгээний явцын оролцоо

	Монгол	БНХАУ	ОХУ	БНСУ	Казакстан	Ботсвана	Перу	Австрали /Күинсланд/
Үнэлгээний талаарх урьдчилсан мэдээлэл, санал авах аргыг олон нийтэд мэдээлдэг үү?	Үгүй	Тийм /Цахим, сонин, самбар/	Үгүй	Тийм /Цахим/	Үгүй	Тийм /ТВ, сонин/	Тийм /Гол сувгаар /	Тийм /Сонин, цахим/
Нарийвчилсан үнэлгээ хийх явцад олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны тайлан боловсруулдаг уу?	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм

### 3. Үнэлгээний тайлангийн төслийн олон нийтийн албан ёсны хэлэлцүүлэг

Үнэлгээний тайлангийн төслийг албан ёсоор олон нийт, иргэдээр хэлэлцүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах хуулийн зохицуулалт Монгол улсын хувьд бусад улсаас онцлог бөгөөд маш тодорхой бус байна. Орон нутгийн ИНХ буюу орон нутгийн өөрөө удирдах ёсны бүтцээр дамжуулж үнэлгээний тайлангийн төслийг хэлэлцдэг зохицуулалт зөвхөн Монгол улсад байна. Энэ нь зөвхөн энэ судалгаанд харьцуулсан улсууд биш бусад олон улсуудын мэдээллээс тодорхой байна. Нөгөөтээгүүр, хэлэлцүүлгийг заавал зохион байгуулах ёстой боловч иргэд, оролцогч талуудад урьдчилж мэдэгдэх, тайлангийн мэдээлэлтэй танилцах хугацаа, мэдээлэл хүргэх арга, хэлбэрийн талаар тодорхой зохицуулалт байхгүй байгаа нь бусад улсаас маш их ялгарч байна.

### Хүснэгт 6. Тайлангийн төслийн хэлэлцүүлэг

	Монгол	БНХАУ	ОХУ	БНСУ	Казакстан	Ботсвана	Перу	Австрали /Күинсланд/
Албан ёсны хэлэлцүүлгийг бие даасан сонгол, хэлэлцүүлэг хэлбэрээр зохион байгуулдаг уу?	Үгүй <b>/ИНХ-аар заавал/</b>	Тийм /Шаардла гатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардла агатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардла гатай бол/	Тийм /Заавал/	Тийм /Шаардлагатай бол/
Сонгол, хэлэлцүүлгийг зохион байгуулах тухай зар мэдээлэл хүргэх ёстой юу?	Үгүй	Тийм /10-аас цөөнгүй хоногийн өмнө/  /Цахим, сонин, самбар/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/  /Цахим, сонин/		Тийм /20-иос цөөнгүй хоногийн өмнө/  /Цахим, сонин, радио, ТВ/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/  /Сонин/	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/  /Гол сувгаар /	Тийм /30-аас цөөнгүй хоногийн өмнө/  /Сонин, цахим/
Сонгол, хэлэлцүүлэг болохоос өмнө тайлангийн төслийн мэдээллийг иргэдэд нээлттэй байршуулдаг уу?	Үгүй	Тийм /10-аас цөөнгүй хоног/  /Цахим/	Тийм /30-аас цөөнгүй хоног/  /Цахим, цаасаар/	Тийм /20-60 хоног/  /Цахим/	Тийм /30-аас цөөнгүй хоног/  /Цахим, цаасаар/	Тийм /30-аас цөөнгүй хоног/	Тийм /30-аас цөөнгүй хоног/	Тийм/ 30-аас цөөнгүй хоног/  /Цахим, цаасаар/

Сонгол, хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй тайланг бэлтгэдэг үү?	Үгүй /Хурлын тэмдэглэл/	Тийм	Тийм	Тийм	Тийм	Үгүй /Хурлын тэмдэглэл/	Тийм	Тийм
---	----------------------------	------	------	------	------	----------------------------	------	------

#### 4. БОНБУ-ний тогтолцоо ба олон нийтийн оролцооны уялдаа

БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангахад төрийн байгууллага зөвхөн тайлангийн төслийг хүлээн авч дүн шинжилгээ хийхдээ олон нийтийн оролцооны шаардлагыг хангасан эсэхийг авч үздэг хязгаарлагдмал үүрэгтэй тогтолцоо ОХУ, Монгол улсад байна. Энэ нь мөн хуучин Зөвлөлтийн экологийн экспертиз буюу төрийн мэргэжлийн зөвлөлийн загвараа хадгалсан төв Ази, ТУХН-ийн улсуудад нийтлэг байна. Зарим улсууд, тухайлбал Казакстан олон нийтийн оролцоог хангахад төрийн дэмжлэг, хяналтыг бий болгох талаар өөрчлөлт хийж байна. Австрали, Перу, БНХАУ-д төр нь иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, санал гомдол хүлээн авах, үйл явцын үнэн зөв байдалд хяналт тавих, маргаан зөрчилдөөнийг зохицуулахад оролцож байна.

#### Хүснэгт 7. Үнэлгээний тогтолцоо ба оролцоо

	Монгол	БНХАУ	ОХУ	БНСУ	Казакстан	Ботсвана	Перу	Австрали /Күинсланд/
Олон нийтийн оролцоог хангахад төрийн эрх бүхий байгууллага идэвхтэй оролцдог уу?	Үгүй	Тийм	Үгүй	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм
Төслийн үнэлгээний ангиллаас хамаарсан оролцооны ялгаатай шаардлага тавьдаг уу?	Үгүй	Тийм	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм	Тийм
Олон нийтээс санал авах үйл явц нь шийдвэр гаргах буюу зөвшөөрөл олгож буй хэрэг биш гэдгийг хууль, журамд тусгасан уу?	Үгүй	Тийм	Тийм	Тийм	Тийм		Тийм	Тийм

ОХУ, Монгол улсаас бусад улсад төслийн үнэлгээний нарийвчилсан ангиллаас хамаарч оролцооны ялгаатай шаардлага, зохицуулалт хэрэгжүүлэх замаар сөрөг нөлөөлөл ихтэй, эрсдэл өндөртэй төслүүдэд илүүтэй анхаарах замаар төрийн байгууллагын ачааллыг зохицуулах, хяналтыг сайжруулахыг зорьдог байна. Харин харьцангуй нөлөөлөл багатай, жижиг, дунд төслүүдэд аль болох авсаархан, гол нөлөөлөлд анхаарсан үнэлгээний хувилбарууд хэрэглэх байдлаар бизнесийн орчинг дэмжиж байна. Ангиллын шалгуур үзүүлэлтүүд аль болох шинжлэх ухааны үндэстэй, тодорхой, тухайн улсын онцлогт тохирсон байх нь оролцогч талуудад ач холбогдолтой болохыг БНХАУ-ын туршлага харуулж байна.

Нөгөө талаас үнэлгээ эрхлэгч байгууллагуудын нөөц боломж, чадавхийг үнэлж, хүний нөөц, хөрөнгө санхүү, чанарын стандартын зохих шаардлага хангасан байгууллагуудаар үнэлгээг чанартай хийлгэх бодлогыг зарим улсууд хэрэгжүүлж байна. Монгол улсад хөрөнгө санхүү, боловсон хүчний нөөц нь хангалтгүй боловч алслагдсан аймаг, сум, багт ажиллаж, нарийвчилсан үнэлгээг дутуу дулимаг, яаруу сандруу хийдэг жишээ байдаг. Үнэлгээ эрхлэгчдийг нөөц боломж, чадавхаар нь ангилах нь компаниудын өрсөлдөх чадвар, хариуцлага сайжрахад сайн нөлөөтэй юм.

Олон нийтээс санал авах үйл ажиллагаа, ялангуяа үнэлгээний тайлангийн төслийг албан ёсоор хэлэлцүүлэх арга хэмжээг талууд шийдвэр гаргаж байгаа эсвэл зөвшөөрөл өгч буй үйлдэл гэж ойлгох хандлага нийтлэг байдаг учраас харьцуулсан дээрх улсуудын хууль, журамд санал авах нь шийдвэр гаргаж буй хэрэг биш болохыг тодорхой дурдсан байна. Монгол улсын хувьд энэ талаар тухайлан дурдсан хуулийн заалт байхгүй бөгөөд харин ИНХ-аар хэлэлцүүлж, санал авах гэдгийг “дэмжсэн санал авах” гэж ойлгож буй байдал практик хэрэглээнд их байна.

## **Дүгнэлт, зөвлөмж**

Энэхүү судалгаанд авч үзсэн улсуудын туршлагаас үзэхэд Монгол улсын БОНБҮ-ний тогтолцоонд олон нийтийн оролцоог хангах зохицуулалт маш ерөнхий, тунхаглалын чанартай байна. Төслийн үнэлгээний талаар зөв ойлголттой болоход шаардлагатай мэдээллийг иргэд эхлээд авах ёстой, түүний дараа тухайн төслийн үнэлгээний талаар асуулт, санал хэлэх боломжтой болно гэдэг суурь зохицуулалт Монгол улсын БОНБҮ-ний хуульд маш тодорхойгүй байна. Бусад улсуудын хууль, журмаар маш тодорхой заасан олон нийтэд зар мэдээ хүргэх хэлбэр, хугацаа, хариуцах этгээдийн талаар Монгол улсын хууль, журамд огт хөндөөгүй байна. Улмаар мэргэжлийн үг хэллэгээр бичсэн олон хуудас үнэлгээний тайлангийн мэдээлэлтэй танилцах тодорхой хэлбэр, арга зам, уншиж ойлгох хугацааг тодорхойлоогүй нь бусад улсаас ялгарч байна.

Үнэлгээний тайлангийн төслийг ИНХ буюу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаар хэлэлцүүлдэг зохицуулалт зөвхөн Монгол улсад байна. Бусад улсуудын хувьд төсөл хэрэгжүүлэгч орон нутгийн захиргаатай хамтран хэлэлцүүлэг, сонсгол зохион байгуулж байна. Энэ нь хэлэлцүүлгийг хурдан шуурхай зохион байгуулах, олон нийтэд урьдчилж зар мэдээ хүргүүлэх, иргэдэд мэдээлэлтэй танилцаж, уншиж судлах хугацаа олгох давуу талуудыг бий болгож байна. Оролцогчдын ирц чухал боловч түүнээс илүүтэй зар мэдээ, үнэлгээний мэдээллийг хүртээмжтэй, нээлттэй байлгахад анхаарч, улмаар хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэх замаар хяналтыг хангахыг зорьж байна.

Нарийвчилсан үнэлгээний эхлэл үеэс буюу Ажлын даалгаврыг боловсруулах шатнаас орон нутгийн иргэдээс санал авах, зөвлөлдөх үйл явцыг хэрэгжүүлж байгаа бусад улсын туршлага нь Монгол улсын хууль, журамд байдаг боловч хэрэгжилтийн хангах нарийвчилсан зохицуулалт үгүйлэгдэж байна.

Монгол улсад БОННУ хийх шаардлагатай төслийн хүрээ маш өргөн, дотор нь ялгасан ангилал байхгүй, түүнээс хамаарч оролцооны шаардлага бүх төслүүдийн үнэлгээнд ижилхэн байдаг нь олон улсын туршлагаас ажиглагдаж байна. БОННУ хийх төслийн хүрээг хумьж, сөрөг нөлөөлөл ихтэй, нийгэм, эдийн засгийн, стратегийн чухал ач холбогдолтой төслүүдийн үнэлгээний чанар, оролцоог сайжруулах бодлого харьцуулсан улсуудад нийтлэг байна. Үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах асуудлыг зөвхөн төсөл хэрэгжүүлэгч эсвэл үнэлгээ эрхлэгч хариуцдаг тогтолцооноос төрийн байгууллага идэвхтэй дэмжих, хяналт тавих байдлаар хамтран ажиллах тогтолцоо руу шилжихэд төслийн зөв ангиллыг тогтоох, орон нутагт эрх мэдэл хуваарилах байдлаар төрийн байгууллагын ачааллыг зөв зохицуулах шаардлага тулгарч байна.

Иймд Монгол улсын БОНБУ-ний тогтолцоон дахь олон нийтийн оролцооны зохицуулалтыг боловсронгуй болгоход дараах шинэчлэл, өөрчлөлтийг хийх шаардлагатай байна. Үүнд:

БОНБУ-ний тогтолцооны төвшинд:

- Ерөнхий үнэлгээ болон БОННУ хийх шаардлагатай төслүүдийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлах
- Зарим төсөлд тохирсон БОННУ-ээс өөр хялбаршуулсан үнэлгээ, зөвшөөрлийн хэлбэрийг нэвтрүүлэх, түүнээс хамаарч Ерөнхий үнэлгээний дүгнэлтийн хүрээ, хүчинтэй хугацаа, олон нийтийн оролцооны шаардлагыг ялгаатай байх
- БОАЖЯ олон нийтийг мэдээллээр хангах, санал хүлээн хүлээн авах, гомдол маргаан шийдвэрлэх, хяналт тавих үүргийг тодорхой, ойлгомжтой болгох
- Үнэлгээний тайлангийн төслийг баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлэх зохицуулалтыг эргэн харж, бие даасан, ил тод хэлэлцүүлгийн хэлбэрт шилжих
- Байгаль орчны мэдээллийн сангийн БОНБУ-ний мэдээлэл нь одоо хэрэгжиж буй үнэлгээний ажлуудыг дэмжих зорилготой цаг үеийн зар мэдээ, олон нийтээс санал авах баримт бичгийн төслийг агуулсан реал-тайм хувилбартай байх
- Үнэлгээ эрхлэгч компаниудыг хүний нөөц, хөрөнгө санхүү, чанарын хяналтын тогтолцоо, туршлагыг харгалзан ангилах, үнэлгээний ангиллаас хамаарч ялгаатай эрх олгох замаар үнэлгээний тайлангийн чанарыг сайжруулах, компаниудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх
- Үнэлгээний тайлангийн төсөл болон батлагдсан хувилбарыг зөвхөн хэвлэгдсэн хэлбэрээр биш бүрэн эхээрээ цахим хувилбараар хүлээн авдаг байх
- БОНБУ-нд олон нийтийн оролцоог хангах, ялангуяа иргэдээс санал авах үйл ажиллагааны зорилго, ач холбогдлыг иргэдтэй зөвлөлдөх гэдэг агуулгаар тайлбарлан сурталчлах
- Хууль, журам зөрчсөн, ёс суртахууны алдаа гаргасан үнэлгээ эрхлэгчдэд хүлээлгэх шийтгэл болон ёс зүйн хариуцлагыг тодорхой болгох

- БОННУ-ний хянан магадалгаа хийх төслийн сонголт, хамрах хүрээ, хариуцлагын талаарх хууль, журмын зохицуулалтыг нарийвчилж, хяналтыг сайжруулах

#### Олон нийтийг мэдээллээр хангах

- Нийтийн зар мэдээ, мэдэгдлийн хэлбэр, хугацаа, агуулга, хариуцлагыг БОНБУ-ний хууль, журмаар нарийвчлан зохицуулах
- Нөлөөллийн үнэлгээний тайлангийн төслийн болон батлагдсан хувилбарыг бүрэн эхээрээ олон нийтэд ил тод, хүртээмжтэй байх, ингэхдээ байгууллагын нууцын зарчмуудыг харгалзах
- Олон нийтэд зар мэдээ, үнэлгээний талаарх мэдээлэл хүргэх үйл ажиллагааг үнэлгээний тайланд тусгах
- Олон нийттэй зөвлөлдөх уулзалт, төслийн тайлангийн хэлэлцүүлэг хийсэн үйл явц, үр дүнг тайлан хэлбэрээр олон нийтэд мэдээлэх
- Нарийвчилсан үнэлгээний тайлан нь мэргэжлийн бус хүмүүс уншиж ойлгоход хялбар техникийн бус хураангуйтай байх
- Байгаль орчны мэдээллийн сангийн үнэлгээний талаарх мэдээлэл нь техникийн бус хэллэгтэй, энгийн ойлгомжтой, товч хувилбартай байх

#### Нарийвчилсан үнэлгээний явцын оролцоог хангах

- Ажлын даалгавар боловсруулах шатнаас иргэдээс санал авах үйл ажиллагааны хэлбэр, хугацаа, хариуцлагыг тодорхойлох
- Төслийн байршил, хэмжээ, чиглэл, орон нутгийн онцлогоос хамаарсан иргэдтэй зөвлөлдөх арга замуудыг хэд хэдэн хувилбартайгаар тодорхойлох
- Олон нийтийн оролцооны эсвэл олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааны тайлан боловсруулах, үнэлгээний тайлан оруулах
- Үнэлгээний явцад зохион байгуулсан олон нийттэй зөвлөлдөх, санал авах үйл ажиллагааны талаар цаг тухайд нь олон нийтэд тайлагнах

#### Үнэлгээний тайлангийн төслийн хэлэлцүүлгийг боловсронгуй болгох нь

- Хэлэлцүүлгийг зохион байгуулахаас 10-30 өдрийн өмнөөс олон нийтэд зарлах хэлбэр, агуулга, хариуцлагыг хууль, журамд тодорхой тусгах
- Тайлангийн төслийг бүхэн эхээр цахимаар болон хэвлэмэл хэлбэрээр уншиж танилцах 10-30 өдрийн хугацаа олгох
- Тайлангийн төслийн талаар асуулт, саналаа цахим болон бичгээр БОАЖЯ болон орон нутгийн эрх бүхий байгууллагад илгээх хэлбэр, хаяг тодорхой байх
- Хэлэлцүүлэгт иргэд, оролцогч талууд сайн дураар оролцох, санал бодлоо бичгээр болон амаар илэрхийлэх боломжоор хангах
- Хэлэлцүүлгийг наад зах нь нэг удаа буюу хэд хэдэн удаа зохион байгуулж, иргэд, оролцогч талуудын оролцоог аль болох бүрэн хангах зохицуулалт хийх
- Хэлэлцүүлгийн зохион байгуулалт, дэг, тайланг журмаар нарийвчлан зохицуулах, холбогдох аргачлал, загвар, маягтуудыг батлах

- Хэлэлцүүлгийн тайланг олон нийтэд тухай бүрд нь буюу хэлэлцүүлэг дууссанаас хойш 5 өдрийн дотор ил тод мэдээлдэг байх
- Хэлэлцүүлэг зохион байгуулагдахад талуудын хооронд маргаан гарсан, хэлэлцүүлэг олон удаа хойшилсон зэрэг тохиолдолд хамтарсан ажлын хэсэг ажиллаж асуудал шийдвэрлэх арга замыг хууль, журамд тусгах
- Хэлэлцүүлгийн үйл явц, үр дүнг, холбогдох баримтыг үнэлгээний тайлангийн Олон нийтийн оролцооны эсвэл олон нийттэй зөвлөлдөх үйл ажиллагааны хэсэгт тусгах

#### Үнэлгээний тайлангийн ил тод байдлыг хангах

- Батлагдсан үнэлгээний тайлангийн олон нийтэд зориулсан /бизнесийн нууцад хамаарах хэсгийг дарсан буюу хассан/ хувилбарыг батлагдсанаас хойш 6-12 сарын хугацаанд цахим хэлбэрээр олон нийтэд нээлттэй байршуулах
- Батлагдсан үнэлгээний тайлангийн олон нийтэд зориулсан /бизнесийн нууцад хамаарах хэсгийг дарсан буюу хассан/ хувилбарыг хэвлэмэл хэлбэрээр орон нутгийн нийтийн номын санд /жишээ нь сумын/ хадгалж, иргэд, сонирхогч талууд чөлөөтэй уншиж танилцах боломжоор хангах

## Хавсралт

### Монгол улс, БНХАУ-ын оролцооны зохицуулалтын харьцуулалт

Үнэлгээний үе шатууд	Монгол улс	БНХАУ
Төлөв байдлын үнэлгээ хийх үед		
Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахын өмнө	2.4.1.орон нутгийн захиргааны байгууллага нь тухайн орон нутагт хэрэгжих төслийн талаарх мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах;	
БОННУ хийлгэх дүгнэлт гаргасны дараа	2.4.2.байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллага нь байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний шийдвэр, тухайн төсөлд иргэд, олон нийтээс өгсөн саналыг байгаль орчны мэдээллийн санд оруулах.	БОННУ хийлгэх шийдвэр гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор төсөл хэрэгжүүлэгч өөрийн цахим хуудас, орон нутгийн хэвлэл мэдээллийн цахим хуудас эсвэл орон нутгийн удирдлагын цахим хуудаснаа дараах мэдээллийг нийтэлнэ. Үүнд: 1. Төслийн суурь мэдээлэл: төслийн нэр, байршил, гол үйл ажиллагаа 2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр, холбоо барих хаяг 3. Үнэлгээ эрхлэгчийн нэр 4. Саналаа илэрхийлэх маягыг хаанаас татаж авч болох тухай 5. Саналын хуудсаа хэрхэн илгээх тухай
Нарийвчилсан үнэлгээ хийх үед	“төслийн нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийж байгаа хуулийн этгээд тайлан боловсруулах явцдаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэд, оршин суугчдаас албан ёсоор санал авч, хэлэлцүүлэг зохион байгуулна” /18.4/  2.6.Төсөл хэрэгжүүлэгч төслийн талаарх ойлголт, эерэг, сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах арга хэмжээний талаар нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдэд дэлгэрэнгүй танилцуулж, иргэд, олон нийтийн оролцоог хангахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлж өгч болно.	
Нарийвчилсан үнэлгээний ажлын тайланг боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлэхийн өмнө	“Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дараах асуудлыг тусгана. Үүнд: ... “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл” /8.4.8/  2.7.Үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж нь төсөл хэрэгжүүлэгчтэй хамтран байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан болон байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулж дууссаны дараа үнэлгээний тайлан, олон нийтийн саналын нэгдсэн дүнг ажлын 15 өдрийн хугацаанд тухайн нутаг дэвсгэрийн баг, хорооны нийтийн хурлаар хэлэлцүүлж санал авна.	Төсөл хэрэгжүүлэгч дараах мэдээллийг олон нийтэд мэдээлнэ: 1. Үнэлгээний тайлангийн төсөлтэй хаанаас танилцаж болох тухай 2. Саналаа хэнд хүргүүлэх тухай 3. Саналын хуудас татаж авах хаяг 4. Бичгээр саналаа хэрхэн гаргах тухай 5. Бичгээр саналаа хэзээ гаргах тухай  Ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд олон нийт санал гаргах боломжтой байна. Хэрэв нөлөөллийн талаар олон тооны асуулт, сөрөг саналууд гарсан бол олон нийтийн хэлэлцүүлэг, сонгол, хурал зэрэг илүү гүнзгий зөвлөлдөх арга хэмжээг төсөл хэрэгжүүлэгч зохион байгуулах ёстой.  Төсөл хэрэгжүүлэгч олон нийтийн гаргасан саналыг анхааралтай шинжлэн үзэж дараах агуулгын хүрээнд тайлан мэдээлэл бэлтгэнэ. Үүнд: 1. Олон нийтийн оролцоог хангах үйл явц, цар хүрээ, авсан арга хэмжээ 2. Саналуудын хэрхэн цуглуулж, дүн шинжилгээ хийсэн тухай 3. Олон нийтийн саналын дагуу авсан арга хэмжээ, хариу тайлбар Төсөл хэрэгжүүлэгч нь БОННУ-ий тайлангийн төслийг төрийн эрх бүхий байгууллагад хүргүүлэхийн өмнө түүнийг бүрэн эхээр нь, олон нийтийн оролцооны тайлан мэдээллийн хамтаар өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна.



<p>Төрийн эрх бүхий байгууллага нарийвчилсан үнэлгээний тайланг хүлээн авсны дараа</p>		<p>Холбогдох эрх бүхий байгууллага БОНБУ-ний тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. БОННУ-ний тайлан бүрэн эхээрээ</li> <li>2. Олон нийтийн оролцооны тайлан мэдээлэл</li> <li>3. Олон нийт саналаа хэрхэн гаргах тухай</li> </ol> <p>Эрх бүхий байгууллага уг мэдээллийг ажлын 10-аас цөөнгүй өдрийн хугацаанд нээлттэй байлгана.</p>
<p>Нарийвчилсан үнэлгээний тайланг шинжилж батлахын өмнө</p>	<p>“Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, түүнд үнэлгээний шинжилгээ хийсэн шинжээчийн болон мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт, энэ хуулийн 18.4-т заасан саналыг үндэслэн төслийг хэрэгжүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ” /10.4/</p> <p>2.10.Нөлөөлөлд өртөж болзошгүй иргэд нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээтэй холбогдсон саналаа тухайн баг, хорооны Иргэдийн нийтийн хуралд төслийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө хүргүүлсэн байна.</p>	<p>Холбогдох эрх бүхий байгууллага БОННУ-ний эцсийн тайланг хүлээн авсны дараа дараах мэдээллийг өөрийн цахим хуудаснаа нээлттэй байршуулна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Төслийн нэр ба байршил</li> <li>2. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр</li> <li>3. Үнэлгээ эрхлэгчийн нэр</li> <li>4. Төслийн хэрэгжүүлэх гол үйл ажиллагаа, байгаль орчны гол нөлөөлөл, хариу арга хэмжээ</li> <li>5. Төсөл хэрэгжүүлэгчийн олон нийтийн оролцоог хангах талаар явуулсан үйл ажиллагаа</li> <li>6. Санал, хүсэлт хэрхэн гаргах тухай</li> </ol> <p>Ажлын 5-аас цөөнгүй өдрийн хугацаанд мэдээллийг ил тод байлгана. Энэ мэдээллийн зэрэгцээ олон нийт болон төсөл хэрэгжүүлэгчид хэрэв хүсэлт гаргавал олон нийтийн сонгол зохион байгуулах боломжтой болохыг мэдэгдэнэ.</p> <p>Эрх бүхий байгууллага нь олон нийтийн саналыг авах хуулийн шаардлагыг биелүүлсэн эсэхийг шалгаж, олон нийтийн саналыг нарийвчлан авч үзнэ. Хэрэв шаардлага хангахгүй бол төслийг буцаана.</p>
<p>Нарийвчилсан үнэлгээ батлагдсаны дараа</p>	<p>10.5.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг төсөл хэрэгжүүлэгч, үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага хамтран төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн оршин суугчдад танилцуулах ажлыг зохион байгуулна.</p> <p>“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэдээллийн санг бүрдүүлэхтэй холбогдсон харилцааг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7-р бүлэгт заасны дагуу зохицуулна” /10.6/</p> <p>2.11.Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний батлагдсан тайланг олон нийтэд нээлттэй байлгах үүргийг төсөл хэрэгжүүлэгч, сум дүүргийн Засаг дарга, баг, хорооны Иргэдийн нийтийн хурал болон аймаг нийслэлийн байгаль орчны газар хариуцна.</p>	<p>Дүгнэлтийг төрийн эрх бүхий байгууллага өөрийн цахим хуудаснаа байршуулна. Мөн энэ талаар захиргааны гомдол гаргах, авч хэлэлцэх талаарх мэдээллийг байршуулна.</p>

Australia Mongolia Extractives Program  
2A Temple View Residence  
Suhbaatar District-1  
Ulaanbaatar  
Mongolia  
T: +976 7000 8595

Энэхүү тайланг Австрали Улсын Засгийн газар, Австралийн Гадаад хэрэг, худалдааны яам санхүүжүүлсэн боловч тус тайланд тусгасан үзэл санаа нь Австрали Улсын Засгийн газрын бус гагцхүү зохиогчийн үзэл бодол болно. Мөн түүнчлэн энэ тайланд тусгасан үзэл баримтлалыг Австрали Улсын Засгийн газар дэмжиж байгаа гэж ойлгож болохгүй. Тус улсын Засгийн газар энэ тайланд багтсан мэдээллийн бүрэн болон үнэн зөв эсэхийг батлахгүй. Энэхүү хэвлэлд орсон тоо баримт, мэдээ материал алдаа мадагтай, дутуу хагас байж болзошгүй бөгөөд түүнээс үүдэн гарах аливаа хохиролд Австрали Улсын Засгийн газар, хариуцлагатай албан тушаалтан, ажилтан, албан хаагч, гэрээт ажилчид ямар нэг хариуцлага хүлээхгүй болно

Энэхүү тайлан нь ерөнхий мэдээлэл өгөх зорилготой. Аливаа шийдвэр гаргахаас өмнө тайланг уншиж, хэрэглэж буй тал мэдээллийн анхдагч эх сурвалжтай холбогдон, мэдээ баримтаа лавшруулан шалгаж, бие даасан судалгаа хийн, зөвлөгөө авах нь зүйтэй